



ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН ЯАМ

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2024 оны IV улирал



Цахим хувилбар

Энэхүү тайланд тусгагдсан үр дүн, тайлбар, дүгнэлт нь Эдийн засаг, хөгжлийн яамны байр суурийг илэрхийлэх албагүй болно.

Уг тайланг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд "Макро эдийн засгийн танилцуулга, 2024 оны 4 дүгээр улирал, Эдийн засаг, хөгжлийн яам" хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу.

Санал хүсэлт болон өөр бусад мэдээллийн талаар асууж тодруулах бол MEPD@med.gov.mn цахим шуудан эсвэл дараах хаягаар хандана уу.

Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг, Ж.Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, Улаанбаатар хот 15141, Монгол Улс

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН
ТАНИЛЦУУЛГА
2024 оны IV улирал

Агуулга

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ	i
БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ	ii
1. БОДИТ СЕКТОР	1
1.1. Нийт нийлүүлэлт	2
1.2. Нийт эрэлт	7
1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж	9
1.4. Эдийн засгийн мөчлөг	13
2. ТӨСВИЙН СЕКТОР	18
2.1. Төсвийн гүйцэтгэл	19
2.2. Төсвийн бодлогын төлөв	24
2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал	25
3. МӨНГӨНИЙ СЕКТОР	28
3.1. Инфляц	29
3.2. Мөнгө ба санхүүгийн салбар	32
4. ГАДААД СЕКТОР	36
4.1. Гадаад худалдаа	37
4.2. Төлбөрийн тэнцэл	40
4.3. Гадаад өр	43
5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ	45
5.1. Дэлхийн эдийн засаг	46
5.2. Түүхий эдийн зах зээл	47
5.3. Олон улсад зарлагдсан индексүүд	48
6. ЭРСДЭЛ	54
Хавсралт	55

Зураг, хүснэгт, шигтгээний жагсаалт

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт (нийлүүлэлт талаас).....	4
Зураг 1.2. Төслийн эдийн засагт үзүүлэх нөлөө.....	6
Зураг 1.3. Бодит ДНБ-ий өсөлт (эрэлт талаас).....	8
Зураг 1.4. Хөдөлмөрийн зах зээл.....	9
Зураг 1.5. Аж ахуйн нэгж.....	12
Зураг 1.6. Үйлдвэрлэлийн зөрүү.....	13
Зураг 1.7. Ажиллах хүчний хомсдол, мянган хүн.....	14
Зураг 1.8. Хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь.....	14
Зураг 1.9. Хэрэглэгчийн итгэлийн индекс, улирлаар.....	15
Зураг 2.1. Төсвийн орлого.....	20
Зураг 2.2. Төсвийн зарлага.....	22
Зураг 2.3. Төсвийн тэнцэл, төсвийн төлөв, автомат тогтворжуулагч.....	24
Зураг 2.4. Засгийн газрын өр.....	25
Зураг 2.5. Засгийн газрын өрийн тогтвортой байдал.....	26
Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн.....	29
Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс.....	30
Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ.....	31
Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд.....	32
Зураг 3.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд.....	33
Зураг 4.1. Экспорт.....	37
Зураг 4.2. Импорт.....	39
Зураг 4.3. Урсгал дансны тэнцэл, гадаад валютын нөөц, төгрөгийн ханш.....	41
Зураг 4.4. Урсгал данс ба гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц.....	42
Зураг 4.5. Гадаад өр.....	43
Зураг 5.1. Авлигын төсөөллийн индексийн оноо, эрэмбэ.....	48
Хүснэгт 1. Төслийн эдийн засагт үзүүлэх нөлөө.....	6
Хүснэгт 2. Дундаж цалингийн хэмжээ (мянган төгрөг).....	10
Хүснэгт 3. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор.....	11
Хүснэгт 4. Хэрэглэгчийн итгэлийн индексийн бүрэлдэхүүн.....	15
Хүснэгт 5. Хуулийн засаглалын индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ, бүлгээр.....	49
Хүснэгт 6. Бизнесийн эрхлэхүйн индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ, шалгуур үзүүлэлтээр.....	51
Хүснэгт 7. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	56
Хүснэгт 8. Бодит секторын үзүүлэлтүүд.....	57
Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд.....	58
Хүснэгт 10. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд.....	59
Хүснэгт 11. Төлбөрийн тэнцлийн үзүүлэлтүүд (ДНБ-д эзлэх хувиар).....	60
Шигтгээ 1. Монгол, Францын хамтарсан Ураны төсөл.....	5
Шигтгээ 2. Ажиллах хүчний хомсдол.....	14
Шигтгээ 3. Хэрэглэгчийн итгэлийн индекс.....	15
Шигтгээ 4. Бизнес эрхлэх орчны үнэлгээ.....	51

Товчилсон үг

ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж, ахуйн нэгжийн орлогын албан татвар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОУВС	Олон улсын валютын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УЦС	Усан цахилгаан станц
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХНХСҮСИ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Худалдаа, үйлчилгээ, уул уурхай болон тээврийн салбаруудын голлох нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг 2024 онд 4.9 хувиар өслөө. Эдийн засгийн идэвхжил өндөр хадгалагдсан нь худалдаа, үйлчилгээний салбаруудын өсөлтийг дэмжсэн бол нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн олборлолт уул уурхайн салбарын өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ. Харин жил дараалсан зудын хүндрэлийн нөлөөгөөр мал аж ахуйн салбарын гарц буурснаар хөдөө аж ахуйн салбарын уналт гүнзгийрч, боловсруулах салбар агшсан нь эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

Эрэлт талаас хэрэглээ, хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Цалин, тэтгэвэр, тэтгэмж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэн, инфляц оны дийлэнх хугацаанд төв банкны зорилтот түвшинд хадгалагдсан нь бодит орлогын өсөлтөд эергээр нөлөөлж, өрхийн хэрэглээг дэмжлээ. Уул уурхайн машин, тоног төхөөрөмжийн импорт болон Оюу толгойн бүтээн байгуулалт болон төмөр, авто зам зэрэг барилга угсралтын ажлууд эрчимжин нийт хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ.

Инфляц 2024 оны сүүлийн улиралд эрчимжлээ. Инфляц 2024 онд дунджаар 6.8 хувь, оны эцэст 9.0 хувьд хүрлээ. Банкны салбарын зээлийн өсөлт сүүлийн 10 жилийн дээд түвшинд хүрч эрчимжсэн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлох нөлөө үзүүлээ. Түүнчлэн, банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн нөхцөл суларч, хялбар зээлийн үйлчилгээнүүд өргөжиж, хэрэглээний зээл өссөн нь эрэлтээр дамжин инфляцад ирэх дарамтыг нэмэгдүүлж байна.

Төсвийн нийт тэнцэл 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.0 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Нүүрсний үнийн бууралт АМНАТ-ийн орлогод сөргөөр нөлөөлсөн ч эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, уул уурхайн голлох бүтээгдэхүүнүүдийн экспортын биет хэмжээ өссөн нөлөөгөөр тэнцвэржүүлсэн орлого 27.0 хувиар өсөж, орлого бүрдүүлэлт сайн байв. Хэдийгээр төсвийн орлого өсөж, нийт тэнцэл ашигтай гарсан ч цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэнтэй холбоотой урсгал зардлын тэлэлт, төрөөс эрчим хүч болон нийтийн тээврийн салбаруудад үнийн зохицуулалт хийх зорилгоор олгосон татаасны нэмэгдэл, мөн төсвийн хөрөнгө оруулалт өмнөх оноос 1.5 дахин өссөнөөр төсвийн зарлага илүү өндрөөр буюу 34.9 хувиар тэлснээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 776.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Урсгал дансны тэнцэл алдагдалтай гарсан ч гадаад санхүүжилтийн орох урсгал нэмэгдсэнээр 2024 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын нөөц нэмэгдлээ. Эдийн засгийн идэвхжилийг дагасан хөрөнгө оруулалт, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импортын өсөлтийн нөлөөгөөр урсгал данс алдагдалтай гарсан ч гадаад зах зээлд гаргасан бондуудын нөлөөгөөр 2024 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын нөөц нэмэгдлээ.

БОГИНО ХУГАЦААНЫ ТӨЛӨВ

Эдийн засгийн өсөлт 2025 оны эцэст 7.5 орчим хувь байхаар тооцоолж байна. Салбаруудаар авч үзвэл, уул уурхайн салбарын өсөлт эрчимжиж, хөдөө аж ахуй, боловсруулах салбаруудын үйлдвэрлэл сэргэх бол үйлчилгээний салбаруудын үйл ажиллагаа тогтвортой байх төлөвтэй байна. Тухайлбал, уул уурхайн салбарт нүүрс болон төмрийн хүдрийн олборлолт өмнөх оноос нэмэгдэж, Оюу толгойн гүний уурхайн нөлөөгөөр баяжмал дахь зэс, алтны агуулга өсөхөөр байгаа нь салбарын өсөлтөд томоохон нөлөөг үзүүлэхээр байна. Мөн Баянхөндийн алтны төсөл 2025 оны сүүлийн хагасаас олборлолт хийж эхэлснээр алтны олборлолтыг нэмэгдүүлнэ. Уул уурхайг дагасан тээврийн салбарын өсөлт болон бөөний болон жижиглэн худалдааны борлуулалт үйлчилгээний салбарын үйл ажиллагааг дэмжиж, нийт үйлчилгээний салбар эдийн засгийн өсөлтөд 2.2 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Түүнчлэн, “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Цагаан алт” хөтөлбөр, “Атар-4” аяны хэрэгжилт хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын өсөлтийг дэмжихээр байна. “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 20-40 хувь, ноосны боловсруулалтын түвшнийг 25-55 хувь, арьс ширний боловсруулалтын түвшнийг 30-50 хувь хүртэл нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Эдгээр зорилтууд нь үйлдвэрлэлийн түвшин, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар салбарын тогтвортой өсөлтийг дэмжихээр байна. Мөн ноолуурыг самнаж экспортлохоор шийдвэрлэсэн нь ноолуурын нэмүү өртгийг нэмэгдүүлж, боловсруулах салбарын өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Мөн газар тариалангийн талбайг нэмэгдүүлж, нэгжээс авах ургацын хэмжээг өсгөх зорилт бүхий “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хэрэгжилт хөдөө аж ахуйн болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжинэ.

Барилгын салбарт томоохон бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт нэмэгдэж, салбарын өсөлтийг дэмжих төлөвтэй байна. Тухайлбал, газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС, Туулын хурдны зам, Сэлбэ дэд төв, Баянхошуу дэд төв, Эмээлт аж үйлдвэрийн парк, Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 2 дугаар блок, Төв аймгийн Баян суманд баригдах 660МВт-ын ДЦС-ын бүтээн байгуулалтын ажил эрчимжихийн зэрэгцээ орон сууцны зориулалттай зээлийн эрэлтийг дагаж орон сууцны барилгын хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил нэмэгдэхээр байна. Эрчим хүчний салбарт өмнөх онд Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 150 МВт-ын хүчин чадал бүхий 1 дүгээр блок ашиглалтад орсон нь салбарын үйлдвэрлэл болон эдийн засгийн потенциалыг нэмэгдүүлнэ.

Эрэлт талаас эдийн засгийн өсөлтийг хөрөнгө оруулалт болон экспорт дэмжих хүлээлттэй байна. Барилгын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажлууд хэрэгжиж эхлэхийн зэрэгцээ 2023-2024 онд тохиосон зудын дараа эх малын тоо, төл бойжилт нэмэгдэх нөлөөгөөр нийт хөрөнгийн хуримтлал өсөж, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх төлөвтэй байна. Нөгөөтээгүүр Оюу толгойн баяжмал дахь зэс, алтны агуулгын өсөлт экспортын бодит өсөлтийг нэмэгдүүлэхээр байна. Харин нийт эрэлтийн 70 орчим хувийг бүрдүүлдэг өрхийн хэрэглээ 2025 онд 5 орчим хувиар өсөх хүлээлттэй байна.

Инфляц 2025 онд дунджаар төв банкны зорилтот түвшнээс өндөр байх хүлээлттэй байна. Тодруулбал, хөдөө аж ахуйн салбарын агшилтаас үүдэлтэйгээр махны нийлүүлэлт буурч, махны үнэ улирлын хандлагаасаа өндрөөр өсөх, цахилгааны тарифын нэмэгдлийн нөлөөгөөр дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх төлөвтэй байна. Мөн 2025 оны 2 дугаар сард нийтийн тээврээр зорчих үнэ шинэчлэгдсэн нь инфляцыг нэмэгдүүлж байна. Цаашид геополитикийн тогтворгүй байдал, уур амьсгалын өөрчлөлт, тээвэр логистикийн саатлаас үүдэн импортын инфляц нэмэгдэх эрсдэлүүд хэвээр байна.

Бүлэг 1

БОДИТ СЕКТОР

- 1.1. Нийт нийлүүлэлт
- 1.2. Нийт эрэлт
- 1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж
- 1.4. Эдийн засгийн мөчлөг

1. БОДИТ СЕКТОР ТОЙМ

Эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, нийлүүлэлт талаас худалдаа, үйлчилгээ, уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбарын өсөлт эдийн засгийн өсөлтийг дэмжсэн бол эрэлт талаас хэрэглээ, хөрөнгө оруулалт өсөлтийг дэмжлээ. Ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувь болж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэн, дундаж цалин 2.5 сая төгрөгт хүрсэн нь өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж, хэрэглээ өсөхөд нөлөөллөө. Уул уурхайн салбарын голлох нөлөөгөөр нийт эдийн засгийн үйлдвэрлэлийн хэмжээ потенциал түвшнээс 1.7 хувь дээгүүр гарлаа.

1.1. Нийт нийлүүлэлт

1. Үйлчилгээний салбаруудын идэвх хадгалагдан, уул уурхай, түүнийг дагасан тээврийн салбарын тэлэлт 2024 оны эдийн засгийн өсөлтийг тэтгэв. ДНБ 2024 онд нэрлэсэн дүнгээр 80 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 13.5 хувиар, бодит дүнгээр 32 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 4.9 хувиар тус тус өслөө. Үйлчилгээний салбарууд, уул уурхай, барилгын салбаруудын үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн бол хөдөө аж ахуй, боловсруулах салбарын гарц буурлаа.

2. Уул уурхайн салбарын өсөлт тогтворжиж, өмнөх оны өндөр түвшнээс 10.8 хувиар тэлэв. Уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийн 1.4 нэгж хувийг бүрдүүлэхэд нүүрс олборлолт 101 сая тоннд хүрч өмнөх оноос 25 хувиар өссөн нь голлон нөлөөлөв. Мөн Оюу толгойн гүний уурхайн үйлдвэрлэл 2024 оны 4 дүгээр улиралд эрчимжиж, хүдрийн агуулга нэмэгдсэнээр үйлдвэрлэсэн зэсийн баяжмал 25 хувиар өсөв. Улмаар нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 1,562 мянган тоннд хүрч, өмнөх оноос 12 хувиар өслөө. Түүнчлэн, төмрийн хүдэр болон баяжмал үйлдвэрлэл 10.1 сая тоннд хүрч, өмнөх оноос 32 хувиар өссөн байна. Харин газрын тосны олборлолт 2024 онд өмнөх оноос 14 хувиар буурч 4.2 сая баррельд хүрсний зэрэгцээ алт олборлолт 12.6 тоннд хүрч, төсөөллөөс доогуур гүйцэтгэлтэй гарсан нь уул уурхайн салбарын өсөлтөд сөрөг нөлөө үзүүллээ. 2025 онд Оюу толгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр зэс, алтны үйлдвэрлэл эрчимжиж, салбарын өсөлтийг нэмэгдүүлэхээр байна.

3. Хөдөө аж ахуйгаас бусад уул уурхайн бус салбаруудын өсөлт өндөр хадгалагдлаа. Уул уурхайн бус салбар 2024 онд 4.0 хувиар (хөдөө аж ахуйгаас бусад уул уурхайн бус салбарын өсөлт 9.5 хувь) тэллээ. Тухайлбал, үйлчилгээний салбарууд, барилга, цэвэр татварын орлогын гүйцэтгэл 2024 онд сайн байсан нь өсөлтийг дэмжсэн бол хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөх оноос буурав.

4. Тээвэр, худалдаа, санхүү, даатгал, мэдээлэл, холбооны салбаруудын үйл ажиллагаа үйлчилгээний салбарын идэвхийг дэмжив. Нийт эдийн засгийн 52 хувийг бүрдүүлж буй үйлчилгээний салбар 2024 онд 9.8 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг 4.8 нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөө үзүүлэв. Үүнд, тээвэр, бөөний болон жижиглэн худалдаа, санхүү болон даатгал, мэдээлэл, холбооны салбаруудын үйлдвэрлэл нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

Хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа өссөнөөр бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 2024 онд 6.6 хувиар тэлэв. Тус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон ажилчдын тоо нэмэгдэж, шинээр олгосон зээл бусад салбаруудтай харьцуулахад хамгийн ихээр өссөнөөр 2024 онд дотоодын худалдааны салбарын идэвх хадгалагдлаа.

Нийтийн хоол болон зочид буудлын салбарын орлого нэмэгдэж, тус салбарын үйл ажиллагаа 2024 онд 8.1 хувиар, урлаг, үзвэрийн үйлчилгээ 8.6 хувиар тус тус өслөө. Мөн мэргэжлийн, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагааны салбар болон захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа 10.2 хувь болон 13.2 хувиар тус тус өсөв. Төрийн удирдлага, боловсрол, эрүүл мэндийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, эдийн засгийн өсөлтөд 0.5 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн байна.

Түүнчлэн, үүрэн холбооны салбарын хөрөнгө оруулалт, сүлжээний бүтээн байгуулалтын өсөлтийн голлох нөлөөгөөр мэдээлэл холбооны салбар 2024 онд 15.5 хувиар өслөө. Мөн санхүү, даатгалын салбарын өсөлт өндөр хадгалагдаж 2024 онд 17.7 хувиар өссөнөөр эдийн засгийн өсөлтийн 0.9 нэгж хувийг бүрдүүллээ.

5. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, дотоодын болон импортын ачаа тээврийн өсөлт тээврийн салбарын өсөлт өндөр хадгалагдахад эергээр нөлөөллөө. Тээврийн салбар 2024 онд

23.1 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийн 1.3 нэгж хувийг дангаараа бүрдүүлэв. Авто замаар өмнөх оноос 22 хувиар их 85.2 сая тонн ачаа, төмөр замаар өмнөх оноос 26 хувиар их 45.9 сая тонн ачаа тус тус тээвэрлэсэн байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэр, тэр дундаа нүүрсний экспортын биет хэмжээ 20 хувиар нэмэгдэж, дотоодын ачаа тээвэр 55 хувиар өссөнөөр тээврийн салбарын ачаа эргэлт нэмэгдлээ. Мөн бүх төрлийн тээврээр зорчсон зорчигчдын тоо өмнөх оны түвшнээс 1.6 хувиар өсөв.

6. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, боловсруулах салбар 1.2 хувиар агшлаа. Хөдөө аж ахуйн салбарын уналтыг даган боловсруулах салбарын 20 орчим хувийг бүрдүүлдэг гурил, мах, самнасан ноолуур, ноолууран сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэл буурч боловсруулах салбарын өсөлтийг хязгаарлалаа. Тухайлбал, үхрийн махны үйлдвэрлэл 4.5 мянган тонн болж өмнөх оноос 48 хувиар, гурилын үйлдвэрлэл 144.5 мянган тонн болж 24 хувиар, самнасан ноолуур 626 тонн болж 46 хувиар, ноолууран сүлжмэл эдлэл 368 мянган ширхэг болж өмнөх оноос 21 хувиар тус тус буурсан байна. Харин дотоод эдийн засгийн идэвхийг даган боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг бүх төрлийн ундааны үйлдвэрлэл тэлж, уул уурхайн салбарын эрчимжилтийг даган тус салбарын 4 орчим хувийг бүрдүүлдэг тэсэлгээний зориулалттай химийн бодис үйлдвэрлэл өссөнөөр боловсруулах салбарын уналтыг саарууллаа. Түүнчлэн, катодын зэсийн үйлдвэрлэл өмнөх оноос 28 хувиар буурч металл үйлдвэрлэлийн өсөлтийг саарууллаа.

7. Инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалт барилгын салбарын өсөлтийг дэмжлээ. Барилгын салбарын үйлдвэрлэлийг орон сууц, орон сууцны бус болон инженерийн барилга байгууламж, их засварын ажил гэсэн ангиллаар тооцон гаргадаг. Барилгын салбар 2024 онд эрчим хүч, далан суваг, шугам сүлжээ,

авто зам зэрэг инженерийн барилга байгууламжийн өсөлтийн голлох нөлөөгөөр 10.4 хувиар өсөж, эдийн засгийн нийт өсөлтийг 0.3 нэгж хувиар дэмжлээ. Тухайлбал, Улаанбаатар хотын Багануур дүүрэгт 50МВт хүчин чадалтай, 200МВт/цагийн багтаамжтай батарей хуримтлуурын станц, Төв аймагт 150МВт хүчин чадалтай Бөөрөлжүүтийн ЦС, Завхан аймагт 22МВт хүчин чадалтай Тосон ДЦС ашиглалтад орж, Сэлэнгэ аймагт 50МВт хүчин чадалтай ДЦС-ын ажил эхэлж эрчим хүчний барилга байгууламж нэмэгдсэн байна. Түүнчлэн, Улаанбаатар-Дархан-Уул чиглэлийн автозамын бүтээн байгуулалт болон Өмнөговь, Ховд, Сэлэнгэ аймгуудын автозамын шинэчлэл, бүтээн байгуулалтууд болон Улаанбаатар хотын авто зам, гүүр, гүүрэн гарц, далан суваг, шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажил барилгын салбарын өсөлтийг голлон дэмжлээ. Харин их засварын ажил, орон сууц болон орон сууцны бус барилгын өсөлтийн хурд өнгөрсөн оны түвшнээс саарсан байна.

8. Эрчим хүч, усан хангамжийн салбарын үйл ажиллагаа тогтвортой байв. Монгол Улс 2024 онд өмнөх оноос 5.5 хувиар их буюу нийт 8,708 сая кВт.ц эрчим хүч (үүнээс цахилгаан эрчим хүч 7,915 сая кВт.ц, сэргээгдэх эрчим хүч 793 сая кВт.ц) үйлдвэрлэсэн бол түгээсэн цэвэр ус өмнөх оны түвшинтэй харьцуулахад 3.5 хувиар нэмэгдлээ. Улмаар, эрчим хүч, усан хангамжийн салбар 2024 онд тэлж, эдийн засгийн өсөлтийн 0.1 нэгж хувийг бүрдүүлэв. Цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл нь эдийн засгийн бусад салбаруудын завсрын хэрэглээнд ашиглагддаг, үйлдвэрлэл тогтвортой явагдахад чухал нөлөөтэй тул цаашид эрчим хүчний салбарт либералчлал, тарифын шинэчлэлийг үргэлжлүүлж, хөрөнгө оруулалт татах, эх үүсвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлж, эрчим хүчний салбарын өсөлтийг тогтвортой бөгөөд өндөр түвшинд хадгалах шаардлагатай.

9. Сүүлийн хоёр жил дараалсан зудын хүндрэлийн нөлөөгөөр том малын зүй бус


хорогдол 9.4 сая толгойд хүрч мал аж ахуйн салбарын гарц буурснаар хөдөө аж ахуйн салбарын уналт гүнзгийрлээ. 2023-2024 оны өвөл нийт нутгийн 90 гаруй хувьд цасан бүрхүүлтэй, өвлийн туршид огцом дулаарал болон хүйтрэл ажиглагдсаны улмаас 14 аймагт мөсөн (төмөр) зуд, харин говийн аймгийн зарим сумдын нутгаар зундаа гантай байснаас харын зудын нөхцөл үүссэн. Он дамнасан зудын хүндрэлийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуй салбарын үйлдвэрлэл сүүлийн хоёр жил дараалан буурснаар 2024 онд хөдөө аж ахуйн салбар 28.7 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 3.6 нэгж хувиар хязгаарлалаа. Тухайлбал, улсын хэмжээнд 9.4 сая толгой том мал хорогдож, төл бойжилт өмнөх оноос 2.1 сая толгой малаар буурч 16.2 сая толгойд хүрснээр нийт малын тоо толгой 57.6 сая болж буурлаа.

Мөн 2024 онд нийт тариалсан талбай өнгөрсөн оноос 1.5 хувиар, нийт тариалсан талбайн 60 орчим хувийг бүрдүүлдэг улаан буудайн тариалсан талбай 5.4 хувиар тус тус буурснаар хураасан улаанбуудайн хэмжээ өмнөх оноос 10.4 хувиар буурч, хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг хязгаарлалаа.

10. Нэмэгдсэн өртгийн албан татвар болон импортын барааны татварын нөлөөгөөр цэвэр татвар эдийн засгийн өсөлтийг 2.0 нэгж хувиар нэмэгдүүлэв. Цэвэр татварын өсөлт 2024 онд өмнөх оноос эрчимжиж, 16.2 хувьд хүрлээ. Дотоодын эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлого 26 хувиар, импортын өсөлтийн нөлөөгөөр импортын барааны НӨАТ-ын орлого 26 хувиар, суудлын автомашины онцгой албан татварын орлого 81 хувиар тус тус өслөө.

Зураг 1.1. Бодит ДНБ-ий өсөлт (нийлүүлэлт талаас)


1.Эдийн засгийн өсөлт дэх салбаруудын оролцоо (нэгж хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт дэх салбаруудын оруулах хувь нэмрийг харуулав.


2.Салбаруудын бодит өсөлт (хувь)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Салбаруудын бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлтийн хувийг харуулав.

3.Хөдөө аж ахуй (мянган толгой мал)



Эх сурвалж: ҮСХ

Тэмдэглэл: Төл бойжилт, том малын зүй бус хорогдлын хэмжээг харуулав.

Хөрөнгө оруулалтын гэрээний танилцуулга

Монгол Улсын Засгийн газар болон Монгол, Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК-ийн хөрөнгө оруулагч Орано Майнинг С.А.С компани Зөөвч-Овоо, Дулаан-Уулын ордуудыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээнд 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр гарын үсэг зурлаа. Тус хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулах, хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, эцэслэсэн хувилбарыг танилцуулахад дэмжлэг үзүүлэх Эдийн засаг, хөрөнгө оруулалтын ажлын дэд хэсгийг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр ахалж, холбогдох албан тушаалтнууд оролцож ажиллав. Монгол, Францын хамтарсан Ураны төсөл нь Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан 14 мега төслийн нэг бөгөөд тус хөрөнгө оруулалтын гэрээ нь Оюу толгойн гэрээнээс хойших эхний гуравдагч хөрш оронтой хийж буй стратегийн чухал ач холбогдол бүхий гэрээ юм.

Төслийг хэрэгжүүлэгч “Бадрах Энержи” ХХК нь Зөөвч-Овоо болон Дулаан-Уулын ураны ордуудын ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг ба Монгол Улсын Их Хурлын 2025 оны “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай” 01 дүгээр тогтоолоор тус ордын төрийн эзэмшлийн 34 хувийн хувьцааг ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөр болон 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд хөрвүүлж, орлуулахаар тооцсон. Улмаар Засгийн газар 34 хувийн энгийн хувьцааг 10 хувийн төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаа болон 5 хувийн ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулж, хөрөнгө оруулалтын гэрээнд туссан өсөн нэмэгдэх хувиар тооцсон ашигт малтмалын малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг авснаар Монгол Улс ногдол ашиг хуваарилах хугацааг хүлээлгүйгээр төсөл хэрэгжиж эхэлснээс хойш төслийн шууд үр өгөөжийг хүртэх боломжтой.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургаадугаар зүйлийн хоёрт “...Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасан. Иймд хөрөнгө оруулалтын гэрээнд Засгийн газар нь төслийн шууд үр өгөөжийн 51-ээс доошгүй хувийг хуримтлагдах дүнгээр жил бүр хүртэх юм. Хэрэв энэ үзүүлэлт 51 хувьд хүрэхгүй тохиолдолд тухайн жилд “Өгөөж тохируулах төлбөр”-ийг нэмэлтээр авахаар Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэн тусгасан. Түүнчлэн, Засгийн газрын төслөөс хүртэх үр өгөөжид АМНАТ, ААНОАТ, төрийн эзэмшлийн давуу эрхийн хувьцаанд ногдох ногдол ашиг, гаалийн албан татвар, өгөөж тохируулах төлбөр гэх мэт шууд үр өгөөжүүдийг хязгаарлагдмал хүрээнд тусгасан бол хөрөнгө оруулагчийн төслөөс хүртэх шууд үр өгөөжид татварын дараах ногдол ашиг, маркетингийн төлбөр, ноу-хауны төлбөр болон зээлийн хүүгийн суутган татварын дараах хүүгийн төлбөрийг оруулахаар тооцсон.

Төслийн санхүүгийн тооцоолол

- Төслийн бүтээн байгуулалт 2024-2027 он хүртэл 4 жил, үйлдвэрлэлийн үе шат 2028-2060 он хүртэл 33 жил, уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үе шат 2061-2070 он хүртэл үргэлжилнэ.
- Төслийн хугацаанд ойролцоогоор нийт 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх бөгөөд үүнээс анхны хөрөнгө оруулалт 500 сая ам.долларыг эхний 4 жилийн хугацаанд хийнэ.
- Төслийн нийт борлуулалтын орлого 14.3 тэрбум ам.доллар бөгөөд улсын төсөвт 5.2 тэрбум ам.долларыг төвлөрүүлж, орон нутгийн хөгжилд 44 сая ам.долларын хөрөнгийг хуваарилна.
- Төслийн нийт шууд үр өгөөж 10,195 сая ам.доллар байх бөгөөд үүнээс Засгийн газарт ногдох үр өгөөж 5,208 сая ам.доллар, хөрөнгө оруулагчид ногдох үр өгөөж 4,987 сая ам.доллар байна.
- Төслийн эхний үе шатанд (2028-2031 он) жилд дунджаар 246 сая ам.долларын экспорт хийнэ. 2032 оноос олборлолт бүрэн хүчин чадалдаа хүрч жилд дунджаар 2,500 тонн уран олборлож, дунджаар 531 сая ам.долларын экспортын орлого олох төлөвтэй байна.
- Төсөл хэрэгжсэнээр нийт 1,600 орчим шинэ ажлын байр нэмэгдэнэ. Үүнээс олборлох, боловсруулах үйлдвэрт 800 орчим, бусад салбарт шууд бусаар 800 орчим ажлын байр нэмэгдэхээр байна.
- Төслийн бүтээн байгуулалтын шатанд Сайншандаас Уурхайн талбай хүртэл 100км цахилгаан дамжуулах агаарын шугам, Зүүнбаянгаас талбай хүртэл 50 км хучилттай авто зам, 500 хүний багтаамжтай уурхайн тосгон, Зүүнбаян сумаас Улаанбадрах сум хүртэлх 60 км сайжруулсан зам зэрэг дэд бүтцийг бүтээн байгуулна.

Эдийн засагт үзүүлэх нөлөө

Монгол, Францыг хамтарсан Ураны төслийн эдийн засагт үзүүлэх нөлөөг Динамик Тооцоолох Ерөнхий Тэнцвэрийн (CGE) загвар ашиглан тооцоолов. Тодруулбал, энэхүү үнэлгээнд 2018 оны Монгол Улсын Нийгмийн тооцооллын матриц (SAM)-


д суурилан PEP-1-т CGE загварын Монголын эдийн засагт тохируулан өргөтгөсөн хувилбарыг ашиглалаа. Төслийн эдийн засагт үзүүлэх нөлөөг 2018 оны эдийн засгийн бүтцэд суурилан төсөл хэрэгжих болон хэрэгжихгүй (суурь хувилбар) гэсэн хоёр хувилбарын зөрүүг тооцоолох замаар тооцоолсон. Ураны төсөл хэрэгжих хувилбарт суурь хувилбарын нөхцөлүүдээс гадна төслийн хөрөнгө оруулалтын шокийг загварт тусгасан болно.

Бүтээн байгуулалтын үе шат 2027 он хүртэл үргэлжилж, 2028 оноос уран олборлож, экспортолж эхлэх бөгөөд 2032 оноос үйлдвэрлэлийн бүрэн хүчин чадалдаа хүрч жилд дунджаар 2,500 тонн ураны исэл олборлоно. Уран олборлолт, үйлдвэрлэл нь зөвхөн хөрөнгө оруулалт, экспорт төдийгүй завсрын хэрэглээгээр дамжуулан уул уурхайн бус салбарын үйлдвэрлэлийг дэмжих, шууд болон шууд бусаар хөдөлмөрийн эрэлтийг нэмэгдүүлэх, татвар, хураамж, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр төсвийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг сувгаар дамжуулан Монгол Улсын эдийн засагт томоохон үр өгөөжийг бий болгоно. Тухайлбал, нэрлэсэн ДНБ-ий өсөлт суурь төсөөлөлтэй харьцуулахад жил бүр дунджаар 1.2 нэгж хувиар, бодит ДНБ-ий өсөлт суурь төсөөлөлтэй харьцуулахад 0.14-0.9 нэгж хувиар нэмэгдэх нөлөөтэй байна. Эдийн засаг дахь хөдөлмөрийн эрэлт нэмэгдсэнээр цалингийн өсөлт суурь төсөөлөлтэй харьцуулахад бүтээн байгуулалтын үед дунджаар 0.5 хувиар, үйлдвэрлэлийн үе шатанд 1.8 хувиар тус тус өндөр байна. Улмаар өрхийн орлого нэмэгдэж, нийт хэрэглээг (суурь төсөөллөөс 1.6 хувиар өндөр өсөх) урамшуулснаар дотоод эрэлтэд эерэг нөлөө үзүүлнэ. Нөгөө талаас цалингийн өсөлт үйлдвэрлэлийн орцын зардлыг нэмэгдүүлж, дотоодын үнийг өсгөх хэдий ч цалингийн өсөлт нь үнийн өсөлтөөс өндөр байна. Түүнчлэн татварын орлогын нөлөөгөөр Засгийн газрын орлогын өсөлт суурь төсөөлөлтэй харьцуулахад дунджаар 1.6 нэгж хувиар өндөр байна. Өрх болон Засгийн газрын орлогыг дагаад хэрэглээ төдийгүй эдийн засаг дахь нийт хадгаламж буюу хөрөнгө оруулалтын эх үүсвэр нэмэгдэнэ. Тухайлбал, нийт хөрөнгө оруулалтын өсөлт уран олборлолтын үе шатанд суурь үеэс жил бүр дунджаар 2.4 нэгж хувиар өндөр байна. Цаашилбал, хэрэглээ, хөрөнгө оруулалтын эрэлтийн нөлөөгөөр импортын өсөлт суурь төсөөлөлтэй харьцуулахад 1.8 нэгж хувиар өндөр байх хэдий ч экспорт жил бүр дунджаар 1.8 нэгж хувиар өндөр өсөх нөлөөтэй байна.

Зураг 1.2. Төслийн эдийн засагт үзүүлэх нөлөө


1.Бодит ДНБ-ий өсөлтийн нөлөө

(хувь)




2.Экспортын нөлөө

(хувь)



3.Хөрөнгө оруулалтын нөлөө

(хувь)



Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

Хүснэгт 1. Төслийн эдийн засагт үзүүлэх нөлөө

Үзүүлэлт	2028–2037 онд жил бүр үзүүлэх нөлөө (Суурь төсөөлөлтэй харьцуулснаар)	
	Дундаж	Доод болон дээд хязгаар
Нэрлэсэн ДНБ	1.2	[1.06, 1.21]
Бодит ДНБ	0.6	[0.14, 0.90]
Хэрэглээний үнийн индекс	0.6	[0.31, 0.91]
Нийт хөрөнгө оруулалт	2.4	[1.89, 3.39]
Экспорт	1.8	[1.66, 1.97]
Импорт	1.8	[1.48, 2.17]
Өрхийн хэрэглээ	1.6	[1.30, 1.85]
Засгийн газрын орлого	1.6	[1.30, 1.85]
Засгийн газрын хөрөнгө оруулалт	5.4	[4.77, 6.07]
Нэрлэсэн цалин	1.8	[1.35, 2.23]

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

1.2. Нийт эрэлт

11. Эдийн засгийн дотоод идэвхжил хадгалагдан, хэрэглээ болон хөрөнгө оруулалтын тэлэлт нийт өсөлтийг дэмжлээ. Өрхийн бодит орлогын өсөлт хэрэглээг дэмжиж, өрхийн хэрэглээ 2024 онд 12.9 хувиар тэллээ. Үүнд хувцас, тавилга, орон сууц зэрэг удаан эдэлгээт бараа, бүтээгдэхүүн болон тээвэр зэрэг үйлчилгээний хэрэглээний өсөлт голлон нөлөөллөө. Засгийн газрын хэрэглээ 2024 онд 18.3 хувиар өсөхөд цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардал 2023 оны түвшнээс 2.3 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Оны сүүлийн хагас жилд биологийн өсөж үрждэг хөрөнгийн хорогдол буурсан ч их засвар, барилга угсралтын ажил идэвхжихийн зэрэгцээ хүнд машин механизмын импорт өссөнөөр эдийн засаг дах хөрөнгө оруулалт 22.2 хувиар нэмэгдэн нийт эрэлтийг дэмжлээ.

12. Өрхийн бодит орлогын өсөлтийн хурд саарлаа. Үнийн өсөлтийн нөлөөг арилгасан өрхийн бодит орлого 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 5.9 хувиар өссөн нь өмнөх улирлаас 4.1 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 9.3 нэгж хувиар доогуур байна. Тэтгэвэр, тэтгэмж болон төрийн албан хаагчдын цалинг 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс нэмэгдүүлсний нөлөөгөөр өрхийн орлого сэргэж, 2023 оны сүүлийн хагас жилээс эхлэн тогтмол 10-аас дээш хувиар нэмэгдсэн. Хэдийгээр оны дийлэнх хугацаанд бараа, үйлчилгээний үнэ тогтвортой байж, хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн нь өрхийн орлогод эерэг нөлөө үзүүлсэн ч оны сүүлээр инфляц алгуур нэмэгдэн, мөн суурь оны өндөр өсөлтийн нөлөөгөөр өрхийн бодит орлогын өсөлт удааширлаа. Түүнчлэн Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си) улирал тутам гаргадаг хэрэглэгчдийн эдийн засагт итгэх итгэлийн индексийн үзүүлэлт 2024 оны сүүлийн улиралд 104.7 болж, өмнөх улирлаас 10.1 нэгжээр бууран хэрэглэгчдийн итгэл оны эцэст суларсан байна.

13. Төв сууринд амьдардаг өрхийн орлого өсөлттэй байгаа ч хөдөөгийн өрхийн мөнгөн

орлого буурч байна. Нийслэлийн өрхүүдийн нэрлэсэн дундаж орлого 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 3.1 сая төгрөгт хүрсэн бол хөдөөгийн өрхүүдийнх 2.1 сая төгрөг байна. Мөн нийслэлийн өрхийн бодит орлого өмнөх оны мөн үеэс 11 хувиар өссөн ч хөдөөгийн өрхийн бодит орлого 4.9 хувиар буурсан байна. Хөдөөгийн өрхийн цалингийн орлого бага байгаагийн дээр мөнгөн орлогын тал орчим хувь нь мал аж ахуй, газар тариалангаас хамаардаг тул цаг уурын таагүй нөхцөлийн улмаас хөдөө аж ахуйн гарц буурсан нь тэдний амьжиргаанд сөргөөр нөлөөлж байна. Монгол Улсад 2023 оны байдлаар бүртгэлтэй нийт 983 мянган өрх байгаагаас 305 мянган өрх нь хөдөө амьдарч байна. Үндэсний статистикийн хорооноос зарласан өрхийн байршил болон орлогын бүлэглэлийн мэдээллийг авч үзвэл 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийслэлийн нийт өрхийн 21.2 хувь нь 1.6 сая төгрөгөөс бага орлоготой байгаа бол хөдөөгийн өрхийн 57.3 хувь нь 1.6 сая төгрөгөөс бага орлоготой байна.

14. Эдийн засаг дахь хөрөнгө оруулалт нэмэгдлээ. Хөрөнгийн хуримтлалд эдийн засаг дах нийт үндсэн болон эргэлтийн хөрөнгийн өсөлт, бууралтыг бүртгэдэг. Хөрөнгийн хуримтлалын эх үүсвэрийн хувьд төсвийн хөрөнгө оруулалт 2024 онд 7.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 53.1 хувиар, шинээр олгосон зээл 57.1 их наяд төгрөгт хүрч 36.7 хувиар тус тус өсөж нийт хөрөнгө оруулалтыг дэмжсэн байна.

Том малын зүй бус хорогдол нэмэгдсэн нь үндсэн хөрөнгийн хуримтлалыг бууруулсан бол уул уурхайн салбарын машин тоног төхөөрөмжийн нөөц 2024 онд 36.3 хувиар өсөж, Улаанбаатар хотод орон сууцны барилга, Өмнөговь, Дорноговь аймгуудад Оюу толгойн бүтээн байгуулалт болон төмөр зам, авто замууд, Хэнтий аймагт хөдөө аж ахуйн цогцолборын ажлууд эрчимжсэнээр барилга байгууламжийн нөөц 22.9 хувиар нэмэгдлээ. Улмаар үндсэн

хөрөнгийн хуримтлал 2024 онд өмнөх оны түвшнээс 19.7 хувиар нэмэгдсэн байна.

15. Бараа, үйлчилгээний импорт өсөж, цэвэр экспорт буурлаа. Цэвэр экспорт нь бараа, үйлчилгээний экспорт болон импортын зөрүүг илэрхийлдэг. Бараа, үйлчилгээний импорт 2024 онд өмнөх оноос 17.7 хувиар нэмэгдэж, цэвэр экспорт 58.9 хувиар буурсан нь эдийн засгийн нийт өсөлтийг 16.4 нэгж хувиар бууруулах нөлөө

үзүүлсэн байна. Барааны импорт 20.2 хувиар өссөний 90 орчим хувийг тоо хэмжээний өсөлт бүрдүүлсэн нь импортын эрэлт өндөр байсныг илтгэж байна. Түүнчлэн, үйлчилгээний худалдааны хувьд бүх төрлийн ачаа тээврийн импорт өссөний зэрэгцээ боловсролын үйлчилгээ болон хувийн зорилгоор гадагш аялах иргэдийн урсгал нэмэгдсэн нь үйлчилгээний импорт өмнөх оны түвшнээс 14.4 хувиар өсөхөд нөлөөлжээ.

Зураг 1.3. Бодит ДНБ-ий өсөлт (эрэлт талаас)

1. Эдийн засгийн өсөлт

(нэгж хувь)




Эх сурвалж: YCX

Тэмдэглэл: Оны эхнээс өсөн нэмэгдсэн дүнгээрх жилийн өсөлтөд оруулсан хувь нэмэр.

2. Өрхийн бодит орлогын өсөлт

(нэгж хувь)



Эх сурвалж: YCX

Тэмдэглэл: Оны эхнээс өсөн нэмэгдсэн дүнгээрх жилийн өсөлтөд оруулсан хувь нэмэр.

3. Үндсэн хөрөнгийн өсөлт

(нэгж хувь)



Эх сурвалж: YCX

Тэмдэглэл: Оны эхнээс өсөн нэмэгдсэн дүнгээрх жилийн өсөлтөд оруулсан хувь нэмэр.


1.3. Хөдөлмөр ба аж ахуйн нэгж

16. Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээл тэлж, ажил эрхлэлт нэмэгдсээр байна. 2024 оны 4 дүгээр улиралд ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 31 мянгаар нэмэгдэж 1 сая 353 мянгад хүрлээ. Ажилчдын тоог улирлын нөлөө¹ арилган тооцвол өмнөх оны мөн үеэс 53 мянгаар нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд үйлчилгээний салбарт 45 мянга, худалдааны салбарт 20 мянга, барилгын салбарт 16 мянган ажилчид нэмэгдсэн нь голчлон нөлөөлсөн байна. Харин хөдөө аж ахуйн салбарын уналтын нөлөөгөөр салбарын ажилчдын тоо өмнөх оны мөн үеэс 27 мянгаар буурсан байна. Мөн боловсруулах салбарын ажилчдын тоо 20 мянгаар, уул уурхайн салбарын ажилчдын тоо 11 мянгаар буурсан нь өсөлтийн хурдыг саарууллаа. Байршлаар авч үзвэл, ажилчдын тоо Улаанбаатар хотод өмнөх оны мөн үеэс 39 мянгаар өсөж 607 мянгад хүрсэн бол хөдөөд 8 мянгаар буурч 746 мянга болсон байна. Тодруулбал, ажилчдын тоо Төвийн бүсэд 10 мянга, Баруун бүсэд 3 мянгаар тус тус буурсан байна. Харин Хангайн бүсэд 3 мянгаар, Зүүн бүсэд 2 мянгаар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

17. Иргэд ажиллах хүчнээс гадуурх хүн амаас ажилчдын эгнээнд шилжсэнээр хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт сайжирлаа. Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 53 мянгаар нэмэгдэж 1 сая 429 мянгад хүрснээр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж хувиар нэмэгдэж 62.2 хувьд хүрлээ. Ажиллах хүчний өсөлтөд ажилчдын тооны өсөлтөөс гадна ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 27 мянгаар буурсан нь эерэг нөлөө үзүүлсэн байна. Үүнд хөдөлмөр эрхлэх сонирхолтой ч ажиллах боломжгүй байсан иргэдийн тоо буурсан нь голчлон нөлөөлсөн байна. Тодруулбал, төрөлтийн тоо 2024 онд өмнөх оноос 6.5 мянгаар буюу 10 хувиар буурч 58 мянгад хүрсэн зэргээс шалтгаалж жирэмсэн болон хүүхэд асарч буй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 14 мянгаар буурсан, улирлын чанартай ажил хийдэг иргэдийн тоо 11.5 мянгаар буурсан нь голлон нөлөөлжээ.

18. Мэргэжилд тохирох ажил олдоогүйн улмаас хөдөлмөр эрхлээгүй иргэдийн тоо нэмэгдлээ. Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 22 мянгаар буюу 42 хувиар өсөж 75.4

Зураг 1.4. Хөдөлмөрийн зах зээл



¹ Улирлын нөлөөг арилгах гэдэг нь хугацаан цувааны өгөгдөл дэх улирлын тогтмол хэв шинжүүдийг арилгах статистикийн арга юм. Эдгээр хэв шинжүүд нь цаг агаарын өөрчлөлт, баяр ёслол, сургууль, цэцэрлэгийн хуваарь, хөдөө

аж ахуйн цикл гэх мэт янз бүрийн хүчин зүйлсээс шалтгаалж бий болдог. Энэхүү тогтмол хэлбэлзлийг арилгаснаар өгөгдөл дэх бодит чиг хандлага, мөчлөгийн хөдөлгөөнүүдийг ажиглахад хялбар болгодог бөгөөд өөр өөр хугацааны мэдээллийг хооронд нь харьцуулах боломжийг олгодог.

мянгад хүрэв. Ингэснээр ажилгүйдлийн түвшин 2023 оны 4 дүгээр улиралтай харьцуулахад 1.4 нэгж хувиар өсөж 5.3 хувьд хүрлээ. Ажилгүй иргэдийн тооны өсөлтийг шалтгаанаар харвал, мэргэжилд тохирох ажил олдохгүй байгаа иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 3.8 мянгаар, тухайн жилд сургууль төгссөн шалтгаантай ажилгүй иргэдийн тоо 3 мянгаар нэмэгдсэн бол байгууллага татан буугдсан болон цомхотголд орсон иргэдийн тоо 1.3 мянгаар буурсан байна.

19. Дундаж цалин нэмэгдсэн ч инфляц өссөнөөр худалдан авах чадварын өсөлт саарлаа. Үндэсний статистикийн хорооноос зарласнаар 2024 оны 4 дүгээр улиралд дундаж цалин өмнөх оны мөн үеэс 437 мянгаар өсөж 2 сая 672 мянган төгрөг, голч цалин өмнөх оны мөн үеэс 448 мянган төгрөгөөр өсөж 2 сая 229 мянган төгрөгт хүрсэн байна. Харин бодит цалин 1 сая 830 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 134 мянган төгрөгөөр өслөө.

Дундаж цалинг салбараар авч үзвэл уул уурхайн салбарын цалин хамгийн өндөр буюу 5 сая 402 мянган төгрөг байсан нь өмнөх оны мөн үеэс 277 мянгаар өссөн нь бусад салбартай харьцуулахад хамгийн бага өссөн бол цахилгаан усны салбарын дундаж цалин 3 сая 138 мянган төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 960 мянган төгрөгөөр өссөн нь хамгийн өндөр өсөлттэй байв.

Хөдөлмөрийн зах зээлийн www.zangia.mn цахим хуудаст 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 34 мянган ажлын байр зарлагдаад байна. Ажлын байрны дундаж цалингийн хэмжээ 2 сая 403 мянган төгрөг байна. Салбараар харвал, хамгийн өндөр цалинтай салбарт уул уурхай 2 сая 843 мянга, барилга, үл хөдлөх хөрөнгийн салбар 2 сая 822 мянга, хуулийн үйлчилгээ 2 сая 671 мянган төгрөг байх бол хамгийн бага буюу 2 сая төгрөгөөс бага цалинтай салбарт харуул хамгаалалт, хэвлэл мэдээлэл, үйлчилгээний салбарууд багтаж байна.

Хүснэгт 2. Дундаж цалингийн хэмжээ (мянган төгрөг)

Ажилчдын тооны бүлэг	2023.IV	2024.IV
Нэрлэсэн дундаж цалин	2,235	2,672
Голч цалин	1,781	2,229
Бодит дундаж цалин	1,696	1,830
Зангиа цахим хуудаст зарлагдсан ажлын байрны дундаж цалин	-	2,403

20. Хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийн түвшин хөдөлмөрийн бүтээмжийн улсын дундаж түвшний өсөлтийг саарууллаа. Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс 141.7 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өсөж 6 сая 393 мянган төгрөгт хүрлээ. Салбараар авч үзвэл, уул уурхайн салбарын бүтээмж өмнөх оны мөн үеэс 4 сая 59 мянган төгрөгөөр буюу 28 хувиар өсөж 18 сая 537 мянган төгрөгт хүрсэн нь хөдөлмөрийн бүтээмжийн улсын дундаж түвшнээс ойролцоогоор 3 дахин өндөр байна. Түүнчлэн аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарын бүтээмжийн түвшин өмнөх оны мөн үеэс харгалзан 70 мянган төгрөг, 67 мянган төгрөгөөр өсөж 8 сая 61 мянга, 5 сая 887 мянган төгрөгт хүрлээ. Харин хөдөө аж ахуйн салбарын бүтээмжийн түвшин тус салбарын бууралтын нөлөөгөөр 886.8 мянган төгрөгөөр буюу 38 хувиар буурч 1 сая 465 мянга төгрөг болсон байна.

21. Шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдлээ. 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 261.2 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 24.7 мянгаар нэмэгдлээ. Уг өсөлтийн 19.2 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 6.8 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүлээ. Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдсэн нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна.

Салбараар харвал, худалдаа, үйлчилгээний салбарт шинээр байгуулагдсан ААН 11.4 мянгаар, үйл ажиллагаа явуулж буй ААН 3.8 мянгаар нэмэгдсэн нь ААН-ийн өсөлтийн гол хэсгийг бүрдүүлж байна. Тус салбарт шинээр байгуулагдсан ААН-ийн тоо тухайн улирлын сүүлийн 10 жилийн дундаж болох 13.8 хувийн өсөлтөөс 34.7 хувиар давж өсжээ. Тодруулбал, бүх төрлийн барааны бөөний болон жижиглэнгийн худалдааны ААН-үүд, тэр дундаа хүнс, ундаа, тамхи болон хөдөө аж ахуйн түүхий эд, мал, амьтны худалдаа эрхэлдэг ААН-үүд ихээхэн нэмэгджээ. Үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн хувьд гишүүнчлэл бүхий байгууллага, эмнэлэг, үйлдвэрчний эвлэл, сургалтын төв, компьютер програмчлал, цэвэрлэгээ, бизнесийн зөвлөх үйлчилгээ эрхэлдэг ААН-ийн тоо нэмэгдсэн байна. Гэхдээ худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 2024 оны 4 дүгээр улиралд 5 хувиар өссөн нь 2022, 2023-ийн мөн үеийн өсөлтөд хүрэхгүй байна.

Засгийн газрын 2024 оны "Шинэ хоршоо хөдөлгөөн" өрнүүлэх тухай 166 дугаар тогтоолоор хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын хөнгөлөлттэй зээл олгохоор шийдвэрлэсэн. Үүнтэй холбоотойгоор 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан хоршооны тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.7 дахин, үйл ажиллагаа явуулж буй хоршооны тоо 2.5 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Хоршооны өсөлтийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбарын ААН-ийн тоо сүүлийн 10 жилийн дунджаас үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн хувьд 38.0 хувиар, шинээр байгуулагдсан ААН-ийн хувьд 243.3 хувиар илүү өсөлттэй гарлаа. Задалж харвал мал, амьтан өсгөх, үржүүлэх аж ахуйн үйл ажиллагаа, хөдөө аж ахуй болон ургац хураалтын дараах шатны үйл ажиллагааг дэмжсэн туслах үйл ажиллагаа, холимог фермерийн аж ахуй, нэг наст ургамлын тариалалт эрхэлдэг ААН-үүд нэмэгджээ (Зураг 1.8).

Уул уурхайн салбарын хувьд экспортын өсөлтийн нөлөөгөөр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ийн тоо уул уурхайн салбарт 30, тээврийн салбарт 394 ААН-ээр нэмэгдсэн бол шинээр байгуулагдсан ААН-ийн тоо уул уурхайн салбарт 114, тээврийн салбарт 1037 ААН-ээр нэмэгджээ. Тээврийн салбарт шинээр байгуулагдсан ААН-ийн өсөлт (90.4%) нь сүүлийн 10 жилийн дунджаас 67.2 хувиар өндөр байна.

22. Худалдаа, үйлчилгээ эрхлэгч жижиг ААН-үүд нэмэгдлээ. Бизнес регистрийн санд бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 108.4 мянган ААН-ийн 86.2 хувь буюу 93.5 мянган ААН 1-9 ажилтантай байна. 1-9 ажилтантай жижиг ААН өмнөх оны мөн үеэс 6.2 мянгаар нэмэгдсэнээс 3.8 мянга нь худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна (1-9 ажилтантай ААН-ийн 76 хувь буюу 71.0 мянган ААН худалдаа, үйлчилгээ эрхэлж байна).

Харин *10-19 ажилтантай ААН 6.8 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 557 ААН-ээр нэмэгдэхэд хөдөө аж ахуй, үйлчилгээ, боловсруулах салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ААН-үүд нэмэгдсэн нь нөлөөллөө. Мөн 20-49 ажилтантай 99 ААН, 50-иас дээш ажилтантай 36 ААН шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсний 2/3-ыг үйлчилгээ, 1/5-ыг тээврийн салбар салбар бүрдүүлээ.*

Хүснэгт 3. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тооны өөрчлөлт, ажиллагчдын тоогоор

Ажилчдын тооны бүлэг	ААН тоо, мянга	Өөрчлөлт, хувь	Тайлбар
1-9	93.5	7.1%	ААН-ийн тооны өсөлтийн 4.3 нэгж хувийг худалдаа, үйлчилгээ, 1.3 нэгж хувийг хөдөө аж ахуйн салбар бүрдүүлсэн.
10-19	6.8	8.9%	Өсөлтийн 2/3-ыг хөдөө аж ахуй, 1.2 нэгж хувийг үйлчилгээ, 1.1 нэгж хувийг боловсруулах салбар бүрдүүлсэн.
20-49	5.2	0.8%	Шинээр 99 ААН үйл ажиллагаа явуулж эхэлснээс 69 ААН үйлчилгээ, 16 ААН тээвэр, 6 ААН барилга, 3 ААН боловсруулах, 2 ААН ХАА-н салбарт байна. Харин

			худалдааны салбарт 57 ААН, ус цахилгааны 1 ААН буурсан байна.
50-иас дээш	2.9	0.1%	Шинээр 36 ААН үйл ажиллагаа явуулж эхэлснээс 23 ААН үйлчилгээ, 10 ААН тээвэр, 3 ААН уул уурхайн салбарт байна. Харин худалдааны салбарт 30 ААН, боловсруулах 2 ААН, ХАА, ус цахилгаан тус тус 1 ААН-ээр буурсан байна.
Нийт	108.4	6.7%	

2024 оны 4 дүгээр улирлын байдлаар ААН-ийн бодит борлуулалтын орлого өмнөх оны мөн үеэс 14.1 хувиар өсөж 23.6 их наяд төгрөгт хүрлээ. Уг өсөлтийн 12.0 нэгж хувийг үйлчилгээний салбар, ус, цахилгааны салбар 3.4 нэгж хувийг, хөдөө аж ахуй 2.8 нэгж хувийг, бөөний ба жижиглэнгийн худалдаа 1.2 нэгж хувь, боловсруулах салбар 0.9 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна. Харин уул уурхай болон тээврийн салбарын ААН-ийн орлого өмнөх оны мөн үеэс харгалзан 37.0 болон 3.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

21. ААН-ийн борлуулалтын орлогын өсөлтийн дийлэнхийг үйлчилгээний салбар бүрдүүллээ.


Зураг 1.5. Аж ахуйн нэгж

Үйл ажиллагаа явуулж буй болон үйл ажиллагаа эхлээгүй ААН-ийн тооны өөрчлөлт, салбараар (ААН-ийн тоо)




Эх сурвалж: ҮСХ

Нийт бүртгэлтэй ААН-ийн тоо (мянга)



Эх сурвалж: ҮСХ

ААН-ийн бодит борлуулалт (их наяд төгрөг, 2015=100)



Эх сурвалж: Татварын ерөнхий газар

1.4. Эдийн засгийн мөчлөг

23. Үйлдвэрлэлийн зориулалттай машин, тоног төхөөрөмжийн өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн сэргэлтийн нөлөөгөөр потенциал үйлдвэрлэлийн өсөлт 4 орчим хувьд хадгалагдлаа. Уул уурхайн олборлолтын эрчимжилт, эрчим хүчний салбарын бүтээн байгуулалтын өсөлт, хүнсний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн гаалийн татвар чөлөөлөлтийн голлох нөлөөгөөр машин, тоног төхөөрөмжийн хуримтлал нэмэгдсэнээр үндсэн хөрөнгийн хуримтлал 2024 онд өмнөх оны мөн үеэс бодит дүнгээр 19.7 хувиар өсөж, нийт эдийн засгийн потенциал үйлдвэрлэлийн өсөлт 4 орчим хувьд хадгалагдлаа. Мөн дотоод эдийн засгийн идэвхжилийг даган хөдөлмөрийн зах зээлийн идэвх өндөр байгаа нь потенциал үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжлээ.

24. Уул уурхай, тээврийн салбарын идэвх хадгалагдсанаар 2024 оны төгсгөлд нийт үйлдвэрлэл потенциал түвшнээсээ 1.7 нэгж хувиар дээгүүр гарлаа. Уул уурхайн олборлолт, түүнийг дагасан тээврийн салбарын эрчимжилтийн нөлөөгөөр уул уурхай, тээврийн салбарын үйлдвэрлэл потенциал түвшнээс 1.8 нэгж хувиар дээгүүр гарлаа. Харин 2024 оны сүүл буюу 4 дүгээр улиралд 1.2 сая толгой мал хорогдож, хөдөө аж ахуйн салбарын уналт даамжирснаар уул уурхай, тээврээс бусад салбаруудын үйлдвэрлэл потенциал түвшнээс 0.04 нэгж хувиар доогуур гарахад голлон нөлөөллөө. Улмаар нийт үйлдвэрлэлийн зөрүү 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар потенциал түвшнээс 1.7 нэгж хувиар дээгүүр байна.

Зураг 1.6. Үйлдвэрлэлийн зөрүү

1.Потенциал ДНБ-ий өсөлт

(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Потенциал үйлдвэрлэлийг нэг хувьсагчтай шүүлтүүр буюу Ходрик-Прескотт, олон хувьсагчтай шүүлтүүр буюу Калман шүүлтүүр болон үйлдвэрлэлийн функцийг аргачлалаар тус тус тооцов.

2.Үйлдвэрлэлийн зөрүү

(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол


Тэмдэглэл: Үйлдвэрлэлийн зөрүүг бодит болон потенциал ДНБ-ий зөрүүгээр тооцно. Үйлдвэрлэлийн зөрүүг үйлдвэрлэлийн функцийг аргачлалд тулгуурлан тооцдог байсныг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP загварт тулгуурлан олон хувьсагчийн Калманы шүүлтүүрийн аргаар тооцох аргачлалд шилжүүлэн тооцов.

Шигтгээ 2. Ажиллах хүчний хомсдол

Сүүлийн жилүүдэд олон улсад хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зөрүүтэй байдал нэмэгдэж ажиллах хүчний хомсдол бодитой сорилт болж байна. Манай улсын хувьд ч мөн адил сүүлийн жилүүдэд ажиллах хүчний хомсдол өсөх хандлагатай байна. Судалгаагаар² Монгол Улсад ажиллах хүчний хомсдол 2018 оноос хойш жил бүр дунджаар 8 мянгаар өссөөр 2022 онд гэхэд 4-5 аж ахуйн нэгж байгууллага тутмын нэг нь ажиллах хүчний хомсдолд өртөж, шаардлагатай 48.9 мянган ажилтнаа авч чадаагүй байна. Харин 2023 онд ажиллах хүчний хомсдол огцом буурч 16.2 мянгад хүрсэн байна. Үүнд эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр хөдөлмөрийн зах зээлд ажилчдын тоо нэмэгдэж, ажилгүйдэл буурсан нь нөлөөлсөн байж болох талтай.


Ажиллах хүчний хомсдолын дийлэнх нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклын засвар үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбаруудад ажиглагдсан байна. Хомсдолтой ажил, мэргэжлийн хувьд үйлдвэрлэл, аж ахуйн туслах ажилтан, барилгын туслах ажилтан, жолооч, тогооч, гагнуурчин, худалдагч, барилгын мужаан, сантехникч зэрэг мэргэжлүүд хамгийн их эрэлттэй байжээ.

Зураг 1.7. Ажиллах хүчний хомсдол, мянган хүн



Эх сурвалж: Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа (2013-2024 он), ХНХСҮСИ

Зураг 1.8. Хөдөлмөрийн насны хүн амын нийт хүн амд эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ, Хүн амын хэтийн шинэчилсэн тооцоо 2020-2050 он

Ажиллах хүчний хомсдолын шалтгааныг хөдөлмөрийн эрэлт болон нийлүүлэлт талаас тайлбарлах боломжтой.

- Хөдөлмөрийн эрэлт талын хомсдол буюу ажил олгогчдод тулгарч буй бэрхшээл:
 - Ажил горилогчид аж ахуйн нэгжээс хэт **өндөр цалингийн хүлээлттэй** байдаг буюу ажил олгогчийн хүссэн бага цалингаар ажиллах ажилчид олдохгүй байх,
 - Ажил горилогчид тухайн ажлын байранд шаардагдаж буй **ур чадвараар дутмаг** буюу ажилтан өөр ур чадвар эзэмшсэн байх гэх мэт.
- Хөдөлмөрийн нийлүүлэлт талын хомсдол буюу хөдөлмөрийн насны хүн амын тооны өөрчлөлт:
 - Монгол Улсад 1990-2005 онд жилд дунджаар 45-50 мянган хүүхэд мэндэлсэн нь сүүлийн 30 жилийн дунджаас 15-20 мянгаар бага үзүүлэлт юм. Энэ 16 жилийн хугацаанд нийт төрөлт 240-320 мянгаар буурсан нь ажиллах хүчний нөөцөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлжээ. Өөрөөр хэлбэл 1990-2005 онд төрсөн хүүхдүүд өнөөдөр 18-35 насны бүлэгт багтаж, хөдөлмөрийн зах зээлийн бүрэлдэхүүн болж байна. Тиймээс тухайн үеийн **төрөлтийн бууралт** нь одоогийн ажиллах хүчний нийлүүлэлтэд сорилт дагуулж буйг анхаарах нь зүйтэй. Энэхүү бага төрөлтийн үеийн нөлөө 2028 оноос суларч цаашид хөдөлмөрийн насны хүн амын тоо аажмаар нэмэгдэхээр байна.
 - Ажиллах хүчний хөгжингүй орнууд руу гадагшлах урсгалын** талаар зарим статистик дурдъя. Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор гадаадад оршин сууж буй иргэдийн тоо 10 жилийн өмнөх үзүүлэлтээс 14 хувиар өсөж 122 мянгад хүрсэн. Түүнчлэн 2023 онд хийгдсэн судалгаагаар³ гадаадад оршин сууж буй иргэдийн тоо 106.5 мянга байгаагаас ойролцоогоор 3 хүн тутмын 1 нь БНСУ-д буюу 32 мянган хүн, АНУ-д 13 мянган хүн буюу 12 хувь, Японд 10.7 мянган хүн буюу 10 хувь, БНЧУ-д 7.5 мянган хүн буюу 7 хувь нь оршин сууж байна. Эдгээрээс БНСУ-ыг авч үзвэл, 2024 оны эцсийн байдлаар 57 мянган Монгол иргэн оршин сууж байгаа нь 4 жилийн туршид 14 мянган хүнээр нэмэгдсэн үзүүлэлт болж байна. Үүнд их дээд сургууль, хэлний бэлтгэл сургалтад хамрагдах зорилгоор оршин сууж буй иргэдийн тоо 61 хувиар өссөн нь голчлон нөлөөлжээ.

Мөн Ур чадварын индексийн⁴ Brain Drain үзүүлэлт буюу ур чадвартай боловсон хүчний гадагшлах хандлагыг илэрхийлдэг үзүүлэлтээр манай улс 2021 онд 3.52 оноо авч, 67 улсаас 51 дүгээрт эрэмбэлэгдэж байсан бол 2024 онд оноо нь 2.33 болон буурч, 67 улсаас 63 дугаарт эрэмбэлэгдсэн байна. Энэ нь удирдах ажилтнуудын нүдээр оюунлаг боловсон хүчний гадагшлах урсгал нэмэгдэж байгааг харуулж байна.

Шигтгээ 3. Хэрэглэгчийн итгэлийн индекс

2024 оны 4 дүгээр улиралд хэрэглэгчдийн бизнесийн нөхцөл болон ажлын олдцын одоогийн үнэлэмж ирээдүйн хүлээлттэй сайжирч Хэрэглэгчийн итгэлийн индекс 104.7-д хүрч өмнөх оны мөн үеэс 16.7 нэгжээр нэмэгдлээ.


Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК) болон Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвөөс тооцон гаргадаг Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ)-ээр эдийн засгийн ерөнхий байдал болон өрхийн санхүүгийн байдлын талаар хэрэглэгчид хэр зэрэг өөдрөг бодолтой байгааг хэмждэг. Хэрэглэгчийн итгэлийн индекс нь Өнөөгийн байдлын индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц/, Ирээдүйн хүлээлтийн индекс /бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлого/ гэсэн 2 дэд индекс /5 үзүүлэлтээс бүрдэх/-ээр тооцож байна. Ингэхдээ улс даяар санамсаргүй түүврийн аргаар хэрэглэгчдээс санал асуулга авч 0-200-ийн хооронд үнэлдэг бөгөөд индекс 200-д дөхөх тусам хэрэглэгчийн итгэл өндөр, 0-д дөхөх дусам хэрэглэгчийн итгэл сул, харин индекс 100-тай тэнцүү үед эдийн засаг хэвийн байна гэж үздэг.

ХИИ 2024 оны 4 дүгээр улиралд 104.7-д хүрсэн нь хэрэглэгчдийн эдийн засгийн өнөөгийн байдлыг үнэлэх үнэлэмж сайжирсан нь голчлон нөлөөллөө. Индексийн үнэлгээг бүрэлдэхүүн хэсгээр задалж Хүснэгт 2-т үзүүлэв.

1. Өнөөгийн байдлын индекс: Бизнесийн нөхцөлийн үнэлэмж сайжирч Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 32.9 нэгжээр нэмэгдлээ. Өнөөгийн байдлын индекс нь иргэд эдийн засгийн одоогийн нөхцөл байдлыг бизнесийн нөхцөл болон ажлын олдоц хэр байгаагаар үнэлснээр хэмждэг. 2024 оны 4 дүгээр улиралд Өнөөгийн байдлын индекс 130.5-д хүрч нэмэгдэхэд ажлын олдоц "сайн" гэж үнэлсэн иргэд өмнөх оны мөн үеэс 8.4 нэгжээр, бизнесийн нөхцөл "сайн" гэж үнэлсэн иргэд 4.5 нэгжээр сайжирсан нь нөлөөллөө.

2. Ирээдүйн хүлээлтийн индекс: Хэрэглэгчдийн эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлттэй сайжирч Ирээдүйн хүлээлтийн индекс өмнөх оны мөн үеэс 11.5 нэгжээр нэмэгдлээ. Ирээдүйн хүлээлтийн индекс нь эдийн засгийн ойрын ирээдүйн нөхцөлийг иргэд хэрхэн харж буйг бизнесийн нөхцөл, ажлын олдоц, орлогын хүлээлтийн үнэлгээгээр хэмждэг. 2024 оны 4 дүгээр улиралд Ирээдүйн хүлээлтийн индекс 96.3-д хүрч нэмэгдэхэд хэрэглэгчдийн ирэх 6 сарын ажлын олдоц, бизнесийн нөхцөлийг өөдрөгөөр харах хандлага нэмэгдсэн нь голчлон нөлөөллөө. Харин орлого сайжирна гэсэн иргэд 1.6 нэгжээр нэмэгдсэн ч муудна гэсэн иргэд 1.4 нэгжээр нэмэгдсэн нь иргэд орлогын ялгавартай хүлээлттэй байгааг харуулж байна.

Зураг 1.9. Хэрэглэгчийн итгэлийн индекс, улирлаар (2018=100)



Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)

Тайлбар: ХИИ болон түүний бүрэлдэхүүн индексүүдийг улирлын нөлөөгөөр засварлаж 2018 оны 4 дүгээр улирлын индекстэй харьцуулж тооцсон байна.

Хүснэгт 4. Хэрэглэгчийн итгэлийн индексийн бүрэлдэхүүн

	2023.IV	2024.IV	Өөрчлөлт
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ			
<i>Бизнесийн нөхцөл</i> ▲			
Сайн	6.4	10.9	4.5 ▲
Хэвийн	36.2	36.0	-0.2 ▼
Муу	56.5	51.0	-5.5 ▼
<i>Ажлын олдоц</i> ▲			
Сайн	27.6	36.0	8.4 ▲
Хэвийн	35.4	31.4	-4.0 ▼
Муу	35.4	30.0	-5.4 ▼
ОЙРЫН ИРЭЭДҮЙ			
<i>Бизнесийн нөхцөл</i> ▲			
Сайн	11.4	16.6	5.2 ▲
Хэвийн	58.2	57.1	-1.1 ▼
Муу	28.1	23.4	-4.7 ▼
<i>Ажлын олдоц</i> ▲			
Сайн	20.5	27.6	7.1 ▲
Хэвийн	60.4	53.8	-6.6 ▼
Муу	15.9	15.9	0.0 ●
<i>Орлого</i> ●			
Сайн	20.1	21.7	1.6 ▲
Хэвийн	63.9	60.7	-3.2 ●
Муу	14.2	15.6	1.4 ▲

Эх сурвалж: Үндэсний судалгаа зөвлөгөөний төв (Эн-Ар-Си-Си ХХК)

Бүлэг 2

ТӨСВИЙН СЕКТОР

2.1. Төсвийн гүйцэтгэл

2.2. Төсвийн бодлогын төлөв

2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

2. ТӨСВИЙН СЕКТОР ТОЙМ

Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өссөн нөлөөгөөр төсвийн орлого 31.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 7.0 их наяд төгрөгөөр нэмэгдэж төсвийн нийт тэнцэл 2024 онд 1.0 их наяд төгрөгийн ашигтай гарсан хэдий ч нүүрсний үнийн бууралт АМНАТ-ийн орлогод сөрөг нөлөө үзүүлж байна.

Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хурдтай шийдвэрлэх зорилтуудыг дэвшүүлж, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулан урсгал зардлыг 1.2 их наяд төгрөг, хөрөнгө оруулалтын зардлыг 1.8 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдүүлснээр нийт төсвийн зарлага 2024 оны батлагдсан дүнгээс 11.4 хувиар нэмэгдүүлж 30.4 их наяд төгрөг байхаар нэмэгдүүлэн баталсан. Нийслэл хот дотоод, гадаад үнэт цаас гаргасантай холбогдуулан Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 3 улирал дараалан өсөж 2024 оны эцсийн байдлаар 33.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өслөө.

2.1. Төсвийн гүйцэтгэл

25. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр 776.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2024 оны жилийн эцэст 29.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 6.3 их наяд төгрөг буюу 27.0 хувиар өслөө. Зардал талаас нэгдсэн төсвийн нийт зарлага 30.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 34.9 хувиар өссөнөөр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 776.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Түүнчлэн нэгдсэн төсвийн нийт тэнцэл 1.0 их наяд төгрөг, үндсэн тэнцэл 2.2 их наяд төгрөгийн тус тус ашигтай гарлаа.

26. Эдийн засгийн идэвхжил өндөр байж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь ААНОАТ, НӨАТ-ын орлогыг нэмэгдүүллээ. Нэгдсэн төсвийн нийт орлого 2024 оны жилийн эцэст 31.4 их наяд төгрөгт хүрч өмнөх жилээс 7.0 их наяд төгрөгөөр буюу 28.7 хувиар өссөн дүн гарлаа. Энэхүү өсөлтөд ААНОАТ 2.5 их наяд төгрөг буюу 65.2 хувиар, НӨАТ 1.1 их наяд төгрөг буюу 22.8 хувиар, ХХОАТ 757 тэрбум төгрөг буюу 40.2 хувиар, онцгой албан татвар 300 тэрбум төгрөг буюу 39.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөллөө.

Түүнчлэн уул уурхайн салбарын идэвхжил хэвээр хадгалагдаж нүүрсний экспортын биет хэмжээ 2024 оны жилийн эцэст 83.7 сая тонн-д хүрч өмнөх оны мөн үеэс 20.3 хувиар, зэсийн баяжмалын биет хэмжээ 1.7 сая тоннд хүрч өмнөх оноос 16.2 хувиар өссөн тус салбараас төвлөрөх орлого өндөр хэвээр хадгалагдахад чухал хувь нэмэр оруулсан байна.

27. Түүхий эдийн экспортын биет хэмжээ өндөр байгаа ч дэлхийн зах зээл дэх нүүрсний үнийн бууралт АМНАТ-ийн орлого буурах шалтгаан болжээ. Эрдэс баялгийн голлох бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл АМНАТ-ийн орлогыг нүүрс 64.5 хувь, зэсийн баяжмал 26.0 хувь, алт 3.8 хувь, төмөр 1.8 хувийг тус тус бүрдүүлдэг. Дээрх

орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлдэг нүүрсний дэлхийн зах зээлийн үнэ буурсантай холбоотойгоор 2024 оны сүүлийн 3 сарын АМНАТ-ын орлого тус бүр 403 тэрбум төгрөг, 326 тэрбум төгрөг, 255 тэрбум төгрөг болж шат дараалан буурчээ. Улмаар 2024 оны урьдчилсан гүйцэтгэлээр улсын төсөвт төвлөрүүлсэн АМНАТ-ийн орлого өмнөх оноос 1 хувиар, тогтворжуулах санд төвлөрүүлсэн орлого 49 хувиар тус тус буурсан хэдий ч нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн АМНАТ-ийн нийт орлого 2024 онд 4.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 12.6 хувиар өсжээ.

28. Нийт төсвийн орлогын эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрсөн орлого 32.1 хувийг бүрдүүлж байгаа тул цаашид нүүрсний үнэ үргэлжлэн унах нь төсвийн орлогыг бууруулах эрсдэлтэй байна. Эрдэс баялгийн салбараас төсөвт төвлөрсөн орлого 10.1 их наяд төгрөгт хүрсэн нь нийт төсвийн орлогын 32.1 хувьтай тэнцэж байна. Татварын төрлөөр ангилан харвал эрдэс баялгийн салбараас төвлөрсөн нийт орлогын 40.1 хувь нь ААНОАТ-аас бүрдсэн бол 46.5 хувь нь АМНАТ-аас бүрдсэн байна. Татварын төрөл бүрийн хамгийн өндөр татвар төлдөг 100 аж ахуйн ангиллаар харвал НӨАТ, онцгой албан татвараас бусад бүх ангилалд уул уурхайн салбар харьцангуй давамгайл байна.

Хүснэгт 3. Төсвийн орлогын голлох ангиллын хамгийн өндөр татвар төлөгч 100 ААН-ын салбарын ангилал


	ААНОАТ	АМНАТ	НӨАТ	ХХОАТ
1 Уул уурхай, олборлолт	29	62	14	21
2 Бөөний, жижиглэн худалдаа; машин засвар үйлчилгээ	26	10	23	11
3 Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	12	9	3	14
4 Боловсруулах үйлдвэрлэл	9	8	12	8
5 Барилга	7	1	11	6
6 Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	2		13	8
7 Бусад	13	9	23	30

Иймд салбаруудын төрөлжилтийг нэмэгдүүлэх, эдийн засгийн суурь баазыг тэлэх замаар нэг салбараас хэт хараат байдлыг бууруулах нь чухал байна.

29. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдүүлсэн нь иргэдийн худалдан авалтыг дэмжиж НӨАТ-ын орлогыг нэмэгдүүллээ. 2024 оны 4 дүгээр сард цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэн нь төрийн болон өрхийн хэрэглээг идэвхжүүлсэн байна. Үүний нөлөөгөөр НӨАТ-ын орлого 2024 оны эхний дөрвөн улиралд 5.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар өссөн үр дүн гарчээ.


Зураг 2.1. Төсвийн орлого

1.Төсвийн тэнцэл
(их наяд төгрөг)




Эх сурвалж: Сангийн яам

2.Татварын орлогын өсөлтөд эзлэх хувь, төрлөөр
(хувь)



Эх сурвалж: Сангийн яам

3.Онцгой албан татварын орлого болон суудлын автомашины импорт
(зүүн тэнхлэг: сая төгрөг, баруун тэнхлэг: ширхэг)



Эх сурвалж: УСХ.

31. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт (тодотгол) орууллаа. Монгол Улсад анхны 126 гишүүнтэй Улсын Их Хурал байгуулагдаж, ард иргэдийн сонгуулиар өгсөн саналыг орхигдуулахгүй байх зарчмыг үндэслэн гурван намын хамтарсан ЗГ-ыг байгууллаа. Уг ЗГ "Алсын хараа-2050", Монгол Улсын урт хугацааны бодлого, Шинэ сэргэлтийн бодлого, намуудын мөрийн хөтөлбөрт туссан онцлог заалтуудыг нэгтгэн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, олон жил гацаад байсан бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг эрчимжүүлэх зорилгоор, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай

хуульд өөрчлөлт оруулжээ. Энэ хүрээнд 2024 оны төсвийн тухай хуульд урсгал зардлыг 1.2 их наяд төгрөгөөр, хөрөнгө оруулалтын зардлыг 1.8 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, нийт зарлага анх батлагдсан дүнгээс 11.4 хувь, өнгөрсөн оны мөн үеэс 35.4 хувиар нэмэгдэн 30.5 их наяд төгрөг байхаар баталлаа.

32. Төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан үе шаттай нэмэгдүүлсэн нөлөөгөөр төсвийн урсгал зардал тэлээ. Төсвийн нийт зарлага 2024 онд 30.4 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оноос 7.7 их наяд төгрөг буюу 34.6 хувиар өссөнөөр, ДНБ-ий 38 хувьтай тэнцэж байна. Энэ нь сүүлийн 15 жилийн хугацаа

дахь төсвийн зардлын хамгийн өндөр үзүүлэлт юм. Нийт зардлын өсөлтөд урсгал зардлын өсөлт 5.0 их наяд (22.3 нэгж хувь) төгрөг, хөрөнгийн зардал 2.7 их наяд (12.3 нэгж хувь) төгрөгийг тус тус эзэлсэн байна. Урсгал зардлын дийлэнх хувийг төрийн албан хаагчийн цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж болон зээлийн хүүгийн төлбөр зэрэг хуулиар зохицуулагддаг, өсөн нэмэгдэх зардлууд бүрдүүлдэг. Тэр дундаа ЗГ-аас өрхийн орлогыг дэмжих хүрээнд тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дунджаар 10 хувиар нэмэгдүүлснээр төсвийн цалин, үр дүнд суурилсан урамшууллын зардал 5.4 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2.3 дахин нэмэгдэж, нийт төсвийн зардлын өсөлтийн хамгийн өндөр буюу 13.6 хувийг бүрдүүлээ. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660 мянган төгрөг болгон шинэчилсэнтэй холбоотойгоор тэтгэврийн зардал өмнөх оны мөн үеэс 395.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Улмаар тэтгэвэр тэтгэмжийн зардал нийт зардлын өсөлтийн 6 хувийг эзэлжээ.

33. Засгийн газрын зээлийн хүүгийн төлбөрийн зардал хоёр жил дараалан өсөлттэй гарлаа. Нэгдсэн төсвөөс нийт зээлийн хүүгийн үйлчилгээний төлбөр 2024 онд 1.2 их наяд төгрөгийн төлөлт хийгдсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 45.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Тодруулбал, гадаад зээлийн хүүгийн төлбөрт 1,146.2 тэрбум төгрөг, дотоод зээлийн төлбөрт 48.8 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна. Хүүгийн зардлын хэмжээ 2021 онд -11.0 хувь, 2022 онд -4.5 хувийн бууралттай байсан. Тус үзүүлэлт гадаад өрийн өсөлтийн нөлөөгөөр 2023 онд 44.1 хувь, 2024 онд 3.9 хувиар тус тус өссөн байна. Засгийн газрын зээлийн хүүгийн зардлын хэмжээ 2014-2024 онд дунджаар нэгдсэн төсвийн зарлагын 7.7 хувь, урсгал зардлын 10.1 хувийг тус тус бүрдүүлж байсан бөгөөд 2019 оноос хойш буурч, 2024 онд нэгдсэн төсвийн 3.9 хувь, урсгал зардлын 5.4 хувийг бүрдүүлж өмнөх төсвийн

жилүүдтэй харьцуулахад харьцангуй бууралттай байгаа хэдий ч цаашид өрийн нийт төсвийн ачааллыг бууруулах, урт хугацаанд төсвийн тогтвортой байдлыг сайжруулахад гадаад өрийн өсөлтийг хязгаарлах төсвийн бодлого чухал байна

34. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2020 онд нэмэгдүүлснээс хойш төсвөөс олгох нийгмийн халамжийн шилжүүлгийн дийлэнх хувийг тус зардал эзэлж байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал 2024 онд 2.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 8.4 хувиар буюу 179.8 тэрбум төгрөгөөр өсжээ. Энэхүү зардлын өсөлтөд асаргааны болон халамжийн тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардлын өсөлт голлон нөлөөллөө. 2020 онд цар тахлын үеийн эдийн засгийг сэргээх, эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах хүрээнд 0-18 насны хүүхдүүдэд сар бүр 20,000 төгрөг олгодог байсныг 100,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн. Улмаар 2019 онд нийт нийгмийн халамжийн зардлын 34.1 хувь (229.6 тэрбум төгрөг)-ийг бүрдүүлж байсан хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардал 2020 онд 65.3 хувь (1 их наяд төгрөг), 2021 онд 71.8 хувь (1.3 их наяд төгрөг), 2022 онд 74.0 хувь (1.5 их наяд төгрөг), 2023 онд 71.6 хувь (1.52 их наяд төгрөг), 2024 онд 66.6 хувь (1.54 их наяд төгрөг)-ийг тус тус эзлэх болж, цар тахлын өмнөх нөхцөл байдалтай харьцуулахад хүүхдийн мөнгөн тэтгэмжийн зардлын хэмжээ 4.4–6.7 дахин, эзлэх хувь ойролцоогоор 2 дахин нэмэгджээ.

35. Төрөлтийн түвшин буурч буйтай холбоотойгоор цалинтай ээж, жирэмсэн болон хөхүүл эхийн тэтгэмжийн зардал буурч байна. Төрөлтийн түвшин 2024 онд өмнөх оноос 10 хувиар, жирэмсэн болон хүүхэд асарч буй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 14 мянгаар буурсан нь жирэмсэн болон хөхүүл эхэд олгох тэтгэмжийн зардлыг өмнөх оноос 11.5 хувиар, цалинтай ээж хөтөлбөрийн зардлыг 1.1 хувиар буурахад нөлөөлжээ. Нэгдсэн төсвийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд эзлэх


дээрх зардлуудын хувь хэмжээ жил ирэх тусам буурч байгаа бөгөөд 2019 онд 16.8 хувь (113.5 тэрбум төгрөг)-ийг эзэлж байсан бол энэ онд 4.4 хувь (103.6 тэрбум төгрөг)-д хүрч 12.4 нэгж хувиар буурсан байна.

36. Эрчим хүчний салбар болон нийтийн тээврийн алдагдалд олгох татаас нийт татаасны дийлэнх хувийг бүрдүүлсэн хэвээр байна. Нэгдсэн төсвөөс 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 954.7 тэрбум төгрөгийн татаасыг олгосон бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64.7 хувиар өссөн байна. Төсвийн урсгал зардалд нийт татаасны эзлэх хувь 4.3 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 374.9 тэрбум (1.8 нэгж хувь) төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тодруулбал, эрчим хүчний салбарт болон нийтийн тээврийн байгууллагуудын алдагдалд олгох татаасны хэмжээ 2024 онд нийт татаасны 55 орчим хувийг бүрдүүлж байна. Үүнээс нийтийн тээврийн алдагдалд олгосон татаас 289.4 тэрбум төгрөг өмнөх оны мөн үеэс 74 хувиар өссөн байна. Мөн эрчим хүчний алдагдалд олгох татаас 221.6 тэрбум өмнөх оны мөн үеэс ойролцоогоор 3.1 дахин, хөдөө аж

ахуйн салбарын бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийг дэмжих урамшуулалд 242.9 тэрбум төгрөгийг олгосон нь өмнөх оны мөн үеэс мөн 2.5 дахин тус тус өссөн нь нэгдсэн төсвийн урсгал зардлын гүйцэтгэлд нийт татаасны эзлэх хувь 2013-2023 оны дунджаар 3.4 хувьтай байснаас ойролцоогоор нэгж хувиар өсөхөд голлон нөлөөлөө. Нийтийн тээврийн үндсэн чиглэлийн нийт 18 аж ахуйн нэгж байгууллагын 2 байгууллага нь ОНӨААТҮГ, 16 хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийслэлийн нийтийн тээврийн газрын шилэн дансны эх сурвалжаар 2024 онд төсвөөс тус салбарт олгогдсон татаасны ойролцоогоор 98 хувийг хувийн хэвшлийн байгууллагуудад олгосон байна. Зорчигчийг тээвэрлэх бодит зардлыг жил бүр шинэчлэн тогтоодоггүй нь нийтийн тээврийн алдагдлыг өсгөдөг шалтгаанаар тус салбарт олгох татаасны хэмжээ жил бүр нэмэгдсээр байгаа нь нийтийн тээврийн байгууллагын өртгийн судалгааг хийх, удирдлагын менежментийг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна.


Зураг 2.2. Төсвийн зарлага

1.Төсвийн зарлага, эдийн засгийн ангиллаар (нэгж хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Нэгдсэн төсвийн зарлагын тэлэлтэд эзлэх хувийг тухайн жилийн өссөн дүнгээр тооцов.

2.Төсвөөс олгосон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал, зориулалтаар (хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Нэгдсэн төсвийн урсгал шилжүүлгийн зориулалтаар ангиллын нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардалд эзлэх хувиар тооцов.


3.Төсвөөс олгосон нийт татаасны жилийн өсөлт, зориулалтаар (хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Нэгдсэн төсвөөс төрийн өмчит болон хувийн байгууллагад олгосон татаасны зориулалтаар ангиллыг нийт татаасны жилийн өсөлтөд эзлэх хувиар тооцов.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт (тодотгол) оруулснаар хөрөнгийн зардлыг 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд энэ нь Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах, томоохон хөгжлийн бүтээн байгуулалтыг дэмжихэд чиглэсэн. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалт 2024 оны эцэст 7.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 52.7 хувиар өссөн бол нийт хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 76.3 хувьтай байна. Эдийн засгийн ангиллаар авч үзвэл, нийт хөрөнгө оруулалтын зардлын 67.9 хувийг барилга байгууламж, 18.3 хувийг бусад хөрөнгө, 9.8 хувийг тоног төхөөрөмж, 3.8 хувийг их засварт зарцуулжээ. 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 11.6 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 1323 төсөл, арга хэмжээг 3.8 их наяд төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд уг санхүүжилтийн гүйцэтгэл 78.7 хувьтай буюу 3.0 их наяд төгрөгт хүрсэн байна. Монгол

Зураг 2.3. Нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардал (нэгж хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам
Тэмдэглэл: Хөрөнгө оруулалтын зардлын дүнг тухайн жилийн улирлын өссөн дүнгээр тооцов.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын 38.3 хувь буюу 3.0 их наяд төгрөгийг улсын төсвөөс, 36.5 хувь буюу 2.9 их наяд төгрөгийг орон нутгийн төсвөөс, 25.3 хувь буюу 2.0 их наяд төгрөгийг гадаадын зээлээс бүрдсэн байна.

2.2. Төсвийн бодлогын төлөв

37. Тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад хүүгийн зардал голлон нөлөөлсөн байна. Төсвийн тэнцэлд үзүүлэх төсвийн бодлогын нөлөөг төсвийн төлөв, төсвийн бодлогоос хамаарахгүй эдийн засгийн мөчлөгийн нөлөөг төсвийн автомат тогтворжуулагчаар ⁵, өрийн үйлчилгээний нөлөөг хүүгийн зардлаар илэрхийлэн зураг 2.3-т харууллаа. Төсвийн тэнцэл потенциал ДНБ-ий 1.0 хувьтай тэнцэх алдагдалтай гарахад автомат тогтворжуулагч 0.1 хувь нэгж хувь буюу 110.8 тэрбум төгрөг, төсвийн төлөв 0.4 нэгж хувь буюу 308.0 тэрбум төгрөгийн эерэг нөлөө үзүүлсэн бол хүүгийн зардал 1.5 нэгж хувьтай тэнцэх сөрөг нөлөө үзүүлсэн буюу 1.2 их наяд төгрөгтэй тэнцэх хэмжээнд төсөвт дарамт учруулсан байна. Өөрөөр хэлбэл өмнөх жилүүдийн авсан зээлийн үйлчилгээний төлбөрт 1.2 их наяд төгрөг төлсөн нь төсвийн алдагдалд нөлөөлөх голлох шалтгаан болсон байна.


38. Эдийн засгийн идэвхжилийн нөлөөгөөр автомат тогтворжуулагч сүүлийн 2 жил дараалан төсөвт эерэг нөлөө үзүүллээ. КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засгийн эргэлт саарч автомат тогтворжуулагч 834.0 тэрбум төгрөгтэй тэнцэхүйц хэмжээнд төсөв дарамт учруулж байсан бол сүүлийн 2 жилд иргэдийн бодит орлого нэмэгдэж, эдийн засгийн дотоод эрэлт сайжирсан нөлөөгөөр (зураг 1.2) тус бүр 247.6, 110.8 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээнд төсвийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлсэн байна.

39. Төсвийн импульс эерэг утгатай болсон нь 2024 оны төсвийн бодлого өмнөх онтой харьцуулахад тэлсэн болох нь харагдаж байна. Төсвийн импульс нь төсвийн тэлэх, эсвэл хумих бодлогын хурдыг төсвийн төлөвийн жилийн өөрчлөлтөөр тооцон харуулдаг. Төсвийн импульс 2024 оны эцэст потенциал ДНБ-ий 1.8 хувь буюу 1.4 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа нь төсвийн хумих бодлогын хурд тус хэмжээнд саарсныг илтгэж байна.

Зураг 2.3. Төсвийн тэнцэл, төсвийн төлөв, автомат тогтворжуулагч

1.Төсвийн нийт тэнцэл⁶

(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам

2.Төсвийн төлөв, импульс


(потенциал ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам

3.Үйлдвэрлэлийн зөрүү, автомат тогтворжуулагч

(Зүүн тэнхлэг: потенциал ДНБ-д эзлэх хувь, Баруун тэнхлэг: тэрбум төгрөг)



Эх сурвалж: ЭЗХЯ-ын тооцоолол, Сангийн яам

⁵ Эдийн засгийн тэлэлт буюу сэргэлтийн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрчимжихийн хэрээр төсвийн орлого нэмэгдэж, эсрэгээрээ эдийн засгийн агшилт буюу уналтын үед татварын орлого буурч, ажилгүйдэл өссөнөөр ажилгүйдлийн тэтгэмж гэх мэт төсвийн зардал ямар нэг бодлогын оролцоогүйгээр жамаараа нэмэгддэг. Ийнхүү засгийн газрын төсвийн бодлогоос

үл хамааран төсвийн тэнцэл өөрчлөгдөж, эдийн засгийг тогтворжуулах чиглэлд ажиллаж байгааг төсвийн тэнцлийн автомат тогтворжуулагч гэнэ.

⁶ Энд хүүгийн зардал болон төсвийн төлөвийн эерэг утга нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх учир зурагт ойлгомжтой харагдуулах үүднээс тухайн утгуудыг -1-ээр үржүүлж харууллаа.

2.3. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

40. Нийслэл хот дотоод, гадаад үнэт цаас гаргасантай холбогдуулан Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2 улирал дараалан өсөж 33.4 их наяд төгрөгт хүрлээ. Гадаад бонд болон гадаад зээлийн эргэн төлөлттэй холбоотойгоор 4 улирал дараалан буураад байсан Засгийн газрын өр сүүлийн 2 улирал дараалан өсөж, 2024 оны эцсийн байдлаар 33.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 8.6 хувиар өслөө. Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 41.8 хувьд хүрч өмнөх онтой харьцуулахад 1.9 нэгж хувь буурсан үзүүлэлттэй байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 2024 оны 1 дүгээр сарын 17-ны нэмэлт, өөрчлөлтөөр нийслэл хот хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зориулалтаар гадаад үнэт цаас гаргаж болно хэмээн шинэчлэгдсэн. Тус заалтын хүрээнд нийслэл хот 2024 оны 6 дугаар сард дотоодын зах зээлд 500 тэрбум төгрөгийн бонд гаргасан бол тус оны 11 дүгээр сард 7.75 хувийн купонтой, бондыг Австри улсын Хөрөнгийн биржид хаалттайгаар гаргаж, олон улсаас 500 сая ам.доллар татан төвлөрүүлсэн байна. Улмаар орон нутгийн зээллэг 2.6 их наяд төгрөгт хүрсэн бол Засгийн газрын өрийн баталгааны хэмжээ өмнөх онтой харьцуулахад 148.4 тэрбум

төгрөгөөр өссөн үзүүлэлтэй байна. Түүнчлэн Засгийн газрын дотоод өр өмнөх оноос 166.4 тэрбум төгрөг буюу 71.1 хувиар нэмэгдэж 400.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

41. Нийслэл хотын үнэт цааснаас төвлөрсөн санхүүжилтээр нийгмийн шинж чанартай бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлнэ. Дээр дурдагдсан үнэт цаасны санхүүжилтээр “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл”, “Бөөрөлжүүтийн ДЦС”, “Батарей хуримтлуурын станц”, “Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажил”, “Ариутгах Бохир усны Туул-1 коллектор болон үерийн байгууламж” зэрэг төслүүдийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.


ОУВС-гийн “Article-IV” тайланд төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардал нь эдийн засагт болоод төсөвт үр өгөөжтэй, өндөр гүйцэтгэлтэй төслүүдэд зарцуулагдах шаардлагатайг зөвлөж байжээ. Иймд зээлийн үйлчилгээний төлбөр нэмэгдэж төлөгдөх санхүүжилтүүдийг эдийн засгийн үр өгөөжтэй бүтээн байгуулалтуудад зарцуулах нь чухал.

42. Засгийн газрын нийт өрд гадаад өрийн эрсдэл давамгай байна. 2024 онд Засгийн газрын нийт өрийн 90.6 хувийг гадаад өр

Зураг 2.4. Засгийн газрын өр

1.Засгийн газрын өр


(зүүн тэнхлэг: их наяд төгрөг, баруун тэнхлэг: хувь)



Эх сурвалж: Сангийн яам

2.Засгийн газрын бусад өр, төлбөр


(их наяд төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам
Тайлбар: Бусад өр төлбөрт Засгийн газрын гадаад, дотоод өрд хамаарахаас бусад өрийг ойлгоно.

3.Засгийн газрын гадаад өрийн эргэн төлөлтийн хуваарь

(сая ам.доллар)



Эх сурвалж: Сангийн яам
Тайлбар: Засгийн газрын гадаад өр нь гадаад үнэт цаас, гадаад зээлээс бүрдэнэ.


бүрдүүлж байгаа нь Засгийн газрын өрийг ханшийн шок болон бусад гадаад орчны нөлөөнд мэдрэг болгож байна. Гадаад өрийн эрсдэл өндөр байгаатай холбогдуулан төсвийн алдагдалд үзүүлэх хүүгийн зардлын нөлөө хамгийн өндөр байна. Түүнчлэн 2026-2028 онуудад тус бүр 978 сая ам доллар, 918.5 сая ам.доллар, 1.0 тэрбум ам долларын гадаад зээлийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийх хүлээлттэй байна.

43. Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөвт үндсэн тэнцэл, бодит ДНБ-ий нөлөө өндөр байна. Өрийн тогтвортой байдлын шинжилгээгээр Засгийн газрын өрийн дунд хугацааны төлөв макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдэд хэр мэдрэг байгааг харуулах боломжтой. Өрийн динамик шинжилгээний суурь төсөөллөөр 2025-2027 онуудад харгалзан ДНБ-ий өсөлт 6 хувьд, ДНБ-ий дефлятор сүүлийн болон ханшийн сулрал сүүлийн 10 жилийн дундаж түвшинд, үндсэн тэнцэл төсөөллийн орчимд бусад макро үзүүлэлтүүд 2024 оны түвшинд тогтвортой байхад 2025 онд Засгийн газрын өр ДНБ-ий 38.1 хувьтай тэнцэхээр байна. Голлох үзүүлэлтүүдэд 2025, 2026 онуудад 1 стандарт хазайлт бүхий шок тооцоход, шокийн нөлөөгөөр 2027 онд Засгийн газрын өр суурь түвшнээс 6.4-9.9 хувиар өсөх магадлал харгалзан 25% байна. Энэ нь макро эдийн засгийн тодорхойгүй байдал, шокийн нөлөөнөөс Засгийн газрын өр өндөр мэдрэг болохыг харуулж байна.

44. Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад үндсэн тэнцлийг ашигтай түвшинд байлгах нь чухал байна. Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлсийг өрийн динамик шинжилгээгээр үнэлэв. Засгийн газрын нэрлэсэн өрийн ДНБ-д эзлэх хэмжээ 2020 онд 10.8 хувиар өссөн бөгөөд үүнд үндсэн тэнцлийн алдагдал 6.7 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Харин 2022 онд нэрлэсэн өр 2.4 хувиар буурахад бодит ДНБ-ий өсөлт 2 орчим хувийн эерэг нөлөө үзүүлсэн


Зураг 2.5. Засгийн газрын өрийн тогтвортой байдал

1.Засгийн газрын өрд үзүүлэх нэрлэсэн гадаад хүүгийн болон ханшийн сөрөг шокийн нөлөө
(ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

2.Засгийн газрын өрд нөлөөлөгч хүчин зүйлс
(өөрчлөлтөд эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

валютын ханшийн сулрал 9.3 нэгж хувьтай тэнцэх сөрөг нөлөө үзүүлжээ. Цаашид Засгийн газрын өрийн тогтвортой байдлыг хангахад ДНБ-ий бодит өсөлт болон үндсэн тэнцлийн алдагдал голлох үүрэг гүйцэтгэхээр байна. Иймд цаашид макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь чухал байгааг тус тооцооллын үр дүн харуулж байна.

Бүлэг 3

МӨНГӨНИЙ СЕКТОР

3.1. Инфляц

3.2. Мөнгө ба санхүүгийн салбар

3. МӨНГӨНИЙ СЕКТОР ТОЙМ

Инфляц 2024 оны эцэст 9.0 хувьд хүрч өслөө. Эдийн засгийн идэвхжилээс үүдэлтэйгээр эрэлтийн гаралтай инфляц өсөхийн зэрэгцээ импортын бараа болон үйлчилгээний үнийн өсөлт өмнөх улирлаас эрчимжив. Сүүлийн 2 жил дараалан өрхийн бодит орлого нэмэгдэж, нийт хадгаламжийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ. Банкны салбарын зээлийн өсөлт сүүлийн 10 жилийн өндөр түвшинд хүрч, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голчлон нөлөөлж байна. Мөн банкны салбарын зээлийн чанар болон ашигт ажиллагаа сайжирлаа.

3.1. Инфляц

45. Инфляц 2024 оны 4 дүгээр улиралд төсөөллөөс өндөр гарч, эрчимжлээ. Инфляц 2024 оны 12 дугаар сард 9.0 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар өслөө. Инфляцын 2.5 нэгж хувийг хүнсний бараа, 2.2 хувийг орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш, 1.1 нэгж хувийг хувцас, бөс бараа, гутлын бүлэг, 0.9 нэгж хувийг боловсролын үйлчилгээ бүрдүүллээ. Инфляц өмнөх оны мөн үеэс 1.1 нэгж хувиар өсөхөд өрхийн цахилгааны төлбөр, орон сууцны түрээсийн зардал болон хувцас, бөс бараа, гутлын үнийн өсөлт голчлон нөлөөлсөн байна. Инфляц төсөөллөөс өндөр гарахад мах, автомашин ба зарим үйлчилгээний үнийн өсөлт хүлээлтээс өндөр байсан нь нөлөөлөв.

46. Импортын болон дотоодын бараа, үйлчилгээний инфляц өсөх хандлагатай байв. Импортын барааны инфляц 2024 оны 12 дугаар сард 5.7 хувь гарч, өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар буурч, нийт инфляцын 29.1 хувийг бүрдүүллээ. Гэсэн хэдий ч өмнөх улиралтай харьцуулахад 0.9 нэгж хувиар эрчимжсэн үзүүлэлттэй байна. Импортын барааны инфляцын 92 гаруй хувийг хүнсний бус барааны үнийн өсөлт тайлбарлаж байна. Дотоодын бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 11.8 хувиар өсөж, нийт инфляцын 70.9 хувийг бүрдүүлсэн байна. Дотоодын


инфляцад хүнс болон үйлчилгээний үнийн өсөлт голчлон нөлөөлж байна. Тухайлбал, 2024 оны 12 дугаар сард үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 12.4 хувиар өсөж, инфляцад 3.4 нэгж хувийн нөлөө үзүүлсэн байна. Үйлчилгээний үнийн өсөлт эрчимжихэд өрхийн цахилгааны төлбөр, нийтийн хоолны үйлчилгээний үнэ өссөн нь нөлөөлсөн байна.

47. Эдийн засгийн дотоод идэвхжил хадгалагдсанаар эрэлтийн гаралтай инфляц нийт инфляцын дийлэнх хэсгийг бүрдүүллээ. Эдийн засгийн дотоод идэвхжил хадгалагдсанаар эрэлтийн гаралтай инфляц өсөх хандлагатай байсан бол нийлүүлэлтийн гаралтай инфляц цахилгааны тарифын шинэчлэлээс үүдэлтэйгээр өсөв. Эрэлтийн (суурь) инфляц 7.8 хувьд хүрч, өмнөх улиралтай харьцуулахад 1.2 нэгж хувиар эрчимжлээ. Эрэлтийн инфляц нийт инфляцын дийлэнх буюу 58 хувийг бүрдүүлсэн байна. Нийлүүлэлтийн гаралтай инфляц 11.4 хувь болж, өмнөх улирлаас 4.5 нэгж хувиар өссөн байна.

48. Хүнсний ба хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц өмнөх улирлаас эрчимжив. Хүнсний барааны инфляц 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 8.9 хувьд хүрч, өмнөх улиралтай харьцуулахад 1.2 нэгж хувиар нэмэгдлээ. Нийт инфляцын 2.5 нэгж хувийг

Зураг 3.1. Инфляцын бүрэлдэхүүн


1.Инфляц ба зорилтот түвшин



Эх сурвалж: YCX

Тэмдэглэл: Улирлын инфляцын хувь хэмжээг улирлын сүүлийн саруудаар тооцов.


2.Инфляцын бүрэлдэхүүн



Эх сурвалж: YCX

Тэмдэглэл: Инфляцад өндөр хувь нэмэртэй бараа болон бүлгээр нийт инфляцыг задлан харуулав.

3.Суурь инфляц



Эх сурвалж: YCX

Тэмдэглэл: Суурь инфляцыг хүнс, шатахуун ба хатуу түлшийг нийт инфляцаас хасаж тооцов.

бүрдүүлсэн хүнсний инфляц өмнөх улирлаас өсөхөд мах, махан бүтээгдэхүүний үнэ 17.1 хувиар, өссөн нь томоохон нөлөөг үзүүлээ. Мөн талх, нарийн боовны үнэ жилийн 9.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. Түүнчлэн, хүнсний бус бараа, үйлчилгээний инфляц 8.7 хувь хүрч, өмнөх улирлаас 2.7 нэгж хувиар өслөө. Хүнсний бус инфляц өмнөх улирлаас эрчимжихэд орон сууцны бодит түрээсийн үнэ өмнөх оны мөн үеэс 40.9 хувиар, өрхийн цахилгааны төлбөр 77.9 хувиар болон суудлын автомашины үнэ 6.8 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлэв.

49. Олон улсад чингэлэг тээврийн үнэ болон хүнсний үнийн индекс өмнөх оны мөн үеэс өслөө. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ Улаан тэнгис дэх Суэцийн сувагт үүссэн халдлагын нөлөөгөөр 2024 оны 2 дугаар сараас хойш эрчтэй өсөөд байсан бол 8 дугаар сараас аажмаар буурч эхэлсэн байна. Дэлхийн чингэлэг тээврийн үнэ 2024 оны 4 дүгээр улирлын эцсийн байдлаар 40 фут чингэлэг тутам 3,905 ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 27.1 хувиар, цар тахлын өмнөх үеэс 175 хувиар өндөр байна. Хүнсний үнийн индекс 2024 оны 12 дугаар сард 127 болж, өмнөх оны мөн үеэс 6.7 хувиар өслөө. Дэлхийн зах зээл дээр сүүн бүтээгдэхүүн, ургамлын тос, үр тариа, элсэн чихрийн үнэ буурсан бол махны үнэ өссөн байна. 2024 онд нийлүүлэлтийн сүлжээ хэвийн болж, мөнгөний хатуу бодлогын төлөвийн нөлөөгөөр дэлхийн

инфляц үргэлжлэн буурчээ. 2024 оны эцсийн байдлаар нийт эдийн засгуудын 60 гаруй хувь нь инфляцын зорилтот түвшнээс бага эсвэл үл ялиг өндөр байсан үзүүлэлттэй байна. 2024 оны 12 дугаар сарын байдлаар Хятад, Их-Британи, Турк, Шри-Ланк улсуудын инфляц буурсан бол Орос, Солонгос, Япон, Америк, Евро бүс, Казакстан, Киргизстан улсуудын инфляц өссөн байна.

50. Бодлогын хүү зохистой түвшнээс бага байна.

Төв банк 2024 онд бодлогын хүүг 3 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэсэн ба 2024 оны 4 дүгээр улирлын бодлогын хүүний дундаж түвшин 10 хувь байна. Бодлогын хүүний дундаж түвшин нь бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх Тэйлорын дүрмээр тооцсон хүүний түвшнээс 1.4 нэгж хувиар доогуур гарч, цаашид бодлогын хүүг бууруулах орон зай хомс байна. Түүнчлэн, зээлийн өсөлт, төсвийн тэлэлт, геополитикийн тогтворгүй байдал, худалдааны дайн, өвөлжилт, хаваржилтын хүндрэл зэрэг инфляцыг өсгөх эрсдэлүүд өндөр байгаа тул бодлогын хүүг зохистой түвшинд хадгалах шаардлагатай байна. Түүнчлэн, 2024 оны 4 дүгээр улирлаас эхлэн бодит хүүний зөрүү мөнгөний нөхцөлийг сулруулах нөлөө нэмэгдэж эхэллээ. Зээлийн өсөлт, төсвийн тэлэлт, геополитикийн тогтворгүй байдал, тээвэр логистикийн саатал зэрэг инфляцыг өсгөх эрсдэлүүд өндөр байгаа тул бодлогын хүүг зохистой түвшинд хадгалах шаардлагатай байна.

Зураг 3.2. Тэйлорын хүү, мөнгөний нөхцөлийн индекс

1.Бодлогын хүү ба Тэйлорын хүү

(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Тэмдэглэл: Тэйлорын дүрмээр тооцсон хүү нь бодлогын хүүний зохистой утгыг илэрхийлэх бөгөөд өмнөх улирлын бодлогын хүү, инфляц, инфляцын хүлээлт, нэрлэсэн хүү зэрэг хувьсагчдыг агуулсан тэгшитгэл юм.

2.Мөнгөний нөхцөлийн индекс

(хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол


Тэмдэглэл: Мөнгөний нөхцөлийн индекс нь эдийн засаг дах мөнгөний бодлогын нөлөөг хэмжих үзүүлэлт юм. Мөнгөний нөхцөлийн индексийг Мөнгөний бодлогын шинжилгээний GAP арга зүйг ашиглан тооцоолов.

Зураг 3.3. Голлох бүтээгдэхүүний үнэ


1.Хонины мах (кг/төгрөг)




2.Үхрийн мах (кг/төгрөг)




3.Гурил, 1-р зэрэг (кг/төгрөг)




4.Талх, Атар (төгрөг)




5.Ургамлын тос (төгрөг)



6.Төмс (төгрөг)



7.Сүү, савласан (литр/төгрөг)



8.Дизель түлш (литр/төгрөг)



Эх сурвалж: УСХ

Тэмдэглэл: Голлох зарим бүтээгдэхүүний үнийн динамикийг сараар харуулав.

3.2. Мөнгө ба санхүүгийн салбар

51. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч эхлэв.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2024 оны 4 дүгээр улирлын эцэст 15.2 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 11.7 нэгж хувиар буурлаа. Эх үүсвэр талаас төгрөгийн хадгаламж ба харилцах мөнгөний нийлүүлэлтийг голлон бүрдүүлж байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 13.1 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 4.7 нэгж хувийг төгрөгийн харилцах, 0.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө бүрдүүлсэн бол гадаад валютын хадгаламж ба харилцах 0.4 ба 2.4 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлээ. Байршуулалт талаас мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 16.2 нэгж хувийг дотоод цэвэр актив бүрдүүлсэн бол гадаад цэвэр актив 1.1 нэгж хувиар бууруулав. 2024 оны 12 дугаар сард банкнууд олон улсын зах зээлд бонд гаргасан, гаднын санхүүгийн байгууллагаас зээл авсантай холбоотойгоор гадаад цэвэр активын өсөлт саарсан нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарахад голлон нөлөөлсөн байна. Харин банкнуудын олгосон зээлийн хэмжээ нэмэгдсэнээр дотоод цэвэр актив өсжээ.

52. Зээлийн өсөлт эрчимжсэн хэвээр байна.

Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 36.8 их наяд төгрөг болж, жилийн өсөлт 35.5 хувьд хүрсэн нь сүүлийн


10 жилийн хамгийн өндөр өсөлт болов. Нийт зээлийн үлдэгдлийн 69 хувь буюу 25.4 их наяд төгрөгийг бизнесийн зээл, 31 хувь буюу 11.4 их наяд төгрөгийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Бизнесийн зээлийн үлдэгдлийн өсөлт 2024 оны 4 дүгээр улиралд 35.5 хувь болж, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өссөн байна. Бизнесийн зээлийн өсөлтөд үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны зээл 46.4 хувиар, уул уурхай, олборлолтын зээл 76.2 хувиар, бөөний болон жижиглэн худалдааны зээл 18.8 хувиар, хөдөө аж ахуйн зээл 139.3 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлжээ. Хэрэглээний зээлийн үлдэгдлийн өсөлт 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 35.5 хувиар өсөж, өсөлтийн хурд өмнөх оны мөн үеэс 5.8 нэгж хувиар саарсан байна. Сүүлийн 2 жил дараалан цалин өсөж, улмаар өр орлогын хязгаарлалттай зээл олголт өсөхийн зэрэгцээ хязгаарлалтгүй буюу тэтгэврийн ба хадгаламж барьцаалсан зээл олголт нэмэгдэж, хэрэглээний зээлийн өсөлтөд голлох нөлөө үзүүлээ. Тухайлбал, цалингийн зээл өмнөх оны мөн үеэс 47.2 хувиар, тэтгэврийн зээл 37.6 хувиар, хадгаламж барьцаалсан зээл 20.1 хувиар тус тус өсжээ.

53. Шинээр олгосон зээлийн өсөлт бизнесийн зээлийн хувьд сэргэж, хэрэглээний зээлийн хувьд

Зураг 3.4. Мөнгөний нийлүүлэлт, зээлийн үзүүлэлтүүд

1. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт


(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

2. Бизнесийн зээлийн өсөлт


(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

3. Хэрэглээний зээлийн өсөлт

(хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

саарч эхэллээ. Банкны салбарын 2024 онд шинээр олгосон нийт зээлийн хэмжээ 57.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 15.3 их наяд төгрөгөөр буюу 36.7 хувиар өслөө. Шинээр олгосон зээлийн 64 хувийг бизнесийн зээл, 36 хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байна. Шинээр олгосон зээлийн жилийн өсөлт 2024 онд бизнесийн зээлийн хувьд 40.7 хувьд хүрч өмнөх оноос 11.2 нэгж хувиар эрчимжсэн бол хэрэглээний зээлийн хувьд 30.1 хувьд хүрч өмнөх оноос 9.4 нэгж хувиар саарлаа. Бөөний болон жижиглэн худалдаа, санхүү болон даатгалын үйл ажиллагаа, уул уурхайн салбаруудад зээл олголт нэмэгдсэн нь бизнесийн зээлийн өсөлтөд голлох нөлөө үзүүлэв. Шинээр олгосон хэрэглээний зээлийн өсөлтийн дийлэнх хэсгийг цалин болон хадгаламж барьцаалсан зээл бүрдүүлж байна.


54. Банкны салбарын зээлийн чанар 2016 оноос хойших хамгийн сайн түвшинд хүрлээ. Чанаргүй зээлийн нийт хэмжээ 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 1.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь үргэлжлэн буурч, 2024 оны эцэст 5.1 хувь буюу 2016 оноос хойших хамгийн бага түвшинд хүрлээ. Уг бууралтад уул уурхай, олборлолт, бөөний болон жижиглэнгийн худалдаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарын чанаргүй

зээл буурсан нь голчлон нөлөөлсөн байна. Нөгөө талаас, хэрэглээний буюу цалин, боловсруулах үйлдвэрлэл болон санхүү, даатгалын үйл ажиллагааны чанаргүй зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна.

55. Зээл ба хадгаламжийн харьцаа өслөө. Зээлийн өсөлт эрчимжсэнээр банкны салбарын зээл ба хадгаламжийн харьцаа 2024 оны эцсийн байдлаар 1.39 болж, өмнөх оноос 12 хувиар өссөн байна. Уг харьцаа хэт өндөр болох нь банкны хөрвөх чадварын эрсдэл нэмэгдэж буйг илэрхийлдэг.

56. Банкны салбарын ашигт ажиллагаа сайжрав. Банкны салбарын активын өгөөж 2024 онд 2.4 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар сайжирсан байна. Банкнуудын ашигт ажиллагаа сайжрахад эх үүсвэр талаас төгрөгийн хадгаламж нэмэгдсэн болон зээлийн чанар сайжирсан нь голлох нөлөө үзүүллээ. Банкны салбарын эрсдэлээр жинлэсэн активд ногдох ашгийн харьцаа 2024 оны байдлаар 4.9 хувьд хүрч, өмнөх оноос 0.4 нэгж хувиар нэмэгдсэнээр банкны салбарын ашигт ажиллагаа сайжирсан байна. Ашигт ажиллагаа сайжрахад банкнуудын цэвэр ашиг өссөн болон зээлийн эргэн төлөлт сайжирч, чанаргүй зээлийн хэмжээ буурсан нь гол нөлөө үзүүллээ.

Зураг 3.5. Хадгаламжийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, хүүгийн үзүүлэлтүүд



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанк

Тэмдэглэл: Бодит үйлчилж буй хүү=(1+Зарласан хүүгийн хувь/хүү бодох давтамж)^(Хүү бодох давтамж)-1

57. Иргэдийн болон байгууллагын төгрөгийн хадгаламж өсөв. Банкнуудын нийт хадгаламж 2024 оны 4 дугаар улирлын байдлаар 26.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 20.9 хувиар өслөө. Үүнээс иргэдийн хадгаламж 22.1 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өссөн байна. Тодруулбал, иргэдийн төгрөгийн хадгаламж 18.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 32.3 хувиар өссөн бол иргэдийн валютын хадгаламж 3.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар буурлаа. Харин байгууллагын нийт хадгаламж 4.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 8.5 хувиар өслөө. Байгууллагын төгрөгийн хадгаламж 3.0 их наяд болж, өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар, валютын хадгаламж 1.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өссөн байна. Төгрөгийн хадгаламжийн үлдэгдэлд жигнэсэн дундаж хүү 2024 оны 4 дүгээр улирлын байдлаар 11.8 хувь байгаа бол валютын хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 3.7 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.5 ба 0.3 нэгж хувиар тус тус өсжээ. Иргэдийн төгрөгийн хадгаламжийн өсөлтөд хадгаламжийн хүү болон өрхийн бодит орлогын өсөлт гол нөлөө үзүүлээ.

58. Активын долларжилтын түвшин өмнөх оноос буурсан байна. Мөнгөний нийлүүлэлтэд эзлэх гадаад валютын харилцах ба хадгаламжийн хэмжээ 2024 онд дунджаар 24.9 хувь гарч, өмнөх оноос 6.4 нэгж хувиар буурчээ. Үүнд 2023 оны сүүл үеэс 2024 оны 2 дугаар улирал хүртэлх хугацаанд төгрөгийн ханш чангарч, тогтвортой хадгалагдсан нь нөлөөллөө. Харин 2024 оны 4 дүгээр улиралд төгрөгийн ханш суларснаар активын долларжилт 2024 оны эцэст 22.1 хувь

гарч, өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

59. Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү буурлаа. Мөнгөний бодлогын хүү 2024 оны 9 дүгээр сард буурч, банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2024 оны эцэст 9.9 хувь болж, өмнөх оны мөн үеэс 2.8 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар тус тус буурсан байна.

60. Зээл болон хадгаламжийн бодит үйлчилж буй хүүгийн зөрүү буурах хандлагатай байна. Арилжааны банкнуудын бодит үйлчилж буй зээлийн хүү 2024 оны эцэст 16.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өссөн бол өмнөх улирлаас 0.9 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна. Харин бодит үйлчилж буй хадгаламжийн хүү 12.4 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.2 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.4 нэгж хувиар тус тус өссөн байна. Зээл ба хадгаламжийн бодит үйлчилж буй хүүгийн зөрүү өмнөх оноос 0.1 нэгж хувиар, өмнөх улирлаас 1.4 нэгж хувиар буурлаа.

61. Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үлдэгдлийн өсөлт өндөр байна. 2024 онд нийт 573 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт зээлийн хэмжээ 5.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 56.4 хувиар өссөн байна. Нийт олгосон зээлийн 93.6 хувийг иргэдэд, 6.4 хувийг хуулийн этгээдэд олгосон зээл бүрдүүлжээ. 2024 онд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлдэгчдийн 75.8 хувь буюу 1.7 сая харилцагч финтек зээлийн үйлчилгээгээр 1.3 их наяд төгрөгийн зээл авсан байна. Банк бус санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн жинлэсэн дундаж хүү сарын 3:5 хувь болж, өмнөх оноос 0.2 нэгж хувиар өсжээ.

Бүлэг 4

ГАДААД СЕКТОР

4.1. Гадаад худалдаа

4.2. Төлбөрийн тэнцэл

4.3. Гадаад өр

4. ГАДААД СЕКТОР ТОЙМ

Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ нэмэгдсэн ч нүүрсний үнэ буурсан нь экспортын орлогын өсөлтийг хязгаарлалаа. Эдийн засгийн идэвхилийг дагасан хөрөнгө оруулалт, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импортын өсөлт өндөр хадгалагдлаа. Урсгал дансны тэнцэл алдагдалтай гарсан ч гадаад бондын орох урсгал нэмэгдсэнээр 2024 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад валютын нөөц нэмэгдлээ.

4.1. Гадаад худалдаа

62. Гадаад худалдааны нийт бараа эргэлт нэмэгдэж, худалдааны тэнцэл ашигтай гарлаа. Монгол Улс 2024 онд дэлхийн 160 улстай худалдаа хийж, худалдааны нийт бараа эргэлт 27.4 тэрбум ам.доллар болж, худалдааны тэнцэл 4.2 тэрбум.долларын ашигтай гарлаа.

63. Экспортын орлогын өсөлт саарлаа. Экспорт 2024 оны байдлаар 15.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар өслөө. Өсөлтөд зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн, алтны дэлхийн зах зээл дэх үнэ өссөн зэрэг нь голлон нөлөөллөө. Цаашид, экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ өндөр түвшинд тогтвортой хадгалагдах хэдий ч гадаад орчноос шалтгаалан нүүрс, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний хилийн үнэ буурахаар хүлээгдэж байна.

64. Хилийн боомтуудын тээвэр зохион байгуулалт сайжирч нүүрсний экспортын биет нэмэгдсэн хэдий ч хилийн үнэ буурлаа. Хилийн голлох боомтуудын тээвэр зохион байгуулалт сайжирч, ажиллах цагийн хуваарь уртассанаас шалтгаалан нүүрсний экспорт 83.8 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 20 хувиар нэмэгдлээ. Гэвч хилийн үнэ 19 хувиар буурссанаар нүүрсний экспортын орлого өмнөх оны мөн үеэс 2 хувиар буурч, экспортын өсөлтөд сөрөг нөлөө үзүүлээ.


Цаашид, гадаад орчин дэх коксжих нүүрсний эрэлт тогтвортой байж биет хэмжээ нэмэгдэх хэдий ч хилийн үнэ сэргэх төлөвгүй байна.

65. Зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспорт нэмэгдлээ. Оюутолгойн далд уурхайн нөлөөгөөр зэсийн баяжмалын экспорт 2024 онд 1,695 мянган тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 11 хувиар өслөө. Түүнчлэн, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 7,511 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 31 хувиар өссөн байна. Цаашид зэсийн баяжмал, төмрийн хүдрийн олборлолт тогтвортой нэмэгдэх, дэлхийн зах зээл дэх цэвэр зэсийн үнэ өсөхөөр байна.

66. Цаг агаарын хүндрэлийн улмаас хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспорт буурлаа. Нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрсэн нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортод сөргөөр нөлөөлж, 2024 онд дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 14 хувиар, ноолуурын экспорт 11 хувиар, арьс ширний экспорт 5 хувиар тус тус буурлаа. Цаашид өвөлжилт, хаваржилтын хүндрэл багасаж, худалдааны түнш орнуудтай хийж буй хэлэлцээрийн үр дүнд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх төлөвтэй байна.

Зураг 4.1. Экспорт

1.Экспортын жилийн өсөлт (нэгж хувь)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2.Экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ

Бүтээгдэхүүн	2023	2024	Өсөлт
Зэсийн баяжмал /мян.тонн/	1,525	1,695	11.2%
Нүүрс /сая.тонн/	69.6	83.8	20.3%
Алт /кг/	11.7	11.6	-0.8%
Төмрийн хүдэр /мян.тонн/	5,713	7,511	31.5%
Газрын тос /мян. баррель/	4,730	4,074	-13.9%

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

3.Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн нүүрсний арилжаа



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

67. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны идэвх 2024 оны сүүлийн улирлуудад суларлаа. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 онд нийт 22.4 сая тонн нүүрсийг 2.4 тэрбум ам.доллараар, 2,419 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 167 сая ам.доллараар, 5.4 мянган тонн зэсийн баяжмалыг 12 сая ам.доллараар, 17.6 мянган тонн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг 2.9 сая ам.доллараар тус тус арилжаалаад байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2024 оны эхний хагас жилд 339 арилжаа амжилттай хийгдсэн бол хоёрдугаар хагас жилд арилжааны тоо 232 болж буурлаа. Тэр дундаа нүүрсний арилжааны тоо 2024 оны 5 дугаар сард 55 хүрснээс хойш 12 дугаар сард 15 болж буурсан байна.

68. Эдийн засгийн өсөлт хадгалагдаж, бараа, бүтээгдэхүүний импортын хэмжээ өслөө. Эдийн засаг 11 улирал дараалан өсөж, дотоод идэвхжил нэмэгдсэнээр импорт 2024 онд 11.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.5 хувиар өслөө. Импорт өмнөх оноос 2.4 тэрбум ам.доллараар нэмэгдсэний 60 орчим хувь нь эдийн засаг, үйлдвэрлэлийг дэмжсэн бараа бүтээгдэхүүн байна.

69. Импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл: нийт өсөлтийн 11.6 нэгж хувийг хөрөнгө оруулалтын зориулалттай машин механик, тоног төхөөрөмж, барилгын материал, 10.6 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 3.3 нэгж хувийг нь аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна.

70. Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн завсрын бүтээгдэхүүний импорт өндөр байна. Энэ онд нүүрсний олборлолт 23 хувиар, экспортын биет хэмжээ 20 хувиар тус тус өссөн нь уул уурхайн салбарт ашиглагддаг завсрын бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүллээ. Тухайлбал, экскаватор, шанагт ухагчийн импорт 362 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 2 дахин, ачаа бараа тээвэрлэх тээврийн хэрэгсэл 722 сая ам.долларт хүрч 67 хувиар, дизель түлш 1,296 сая ам.долларт хүрч 17 хувиар тус тус өссөн байна.

71. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын өсөлтөд суудлын автомашины өсөлт голлох нөлөөг үзүүллээ. Өрхийн орлого сайжирч, хэрэглээний зээл нэмэгдэж байгаа нь хэрэглээний бүтээгдэхүүний, тэр дундаа суудлын автомашины импортыг өдөөлөө. Иргэдэд шинээр олгосон зээл 2024 онд 34 хувиар өссөн нь удаан эдэлгээтэй бараа, бүтээгдэхүүний импорт өсөхөд нөлөөлсөн бөгөөд 123 мянган ширхэг суудлын автомашин импортолсон нь өмнөх оны мөн үеэс 67 хувиар өссөн үзүүлэлт юм. Өнгөрсөн онд моторын багтаамж 3501 см³-ээс их том оврын суудлын автомашины импортын өсөлт өндөр байсан бол 2024 онд моторын багтаамж 3500 см³-ээс бага, дунд болон жижиг оврын суудлын автомашины импорт өндөр байв. Суудлын авто машины импорт нэмэгдэж, аймаг, сумдын тэмдэглэлт ойн арга хэмжээний тоо өссөнтэй холбоотойгоор авто бензиний импорт 643 сая ам.долларт хүрч, 23 хувиар өслөө.

72. Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний импорт нэмэгдлээ. Өрхийн бодит орлого сүүлийн зургаан улирал дараалан өсөж, өрхийн хэрэглээ нэмэгдсэнээр хүнсний бүтээгдэхүүний импорт 1,169 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 20 хувиар өслөө. Мөн гурилын үнийн өсөлтийг бууруулж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд улаан буудайн гурилын импортод хязгаар тогтоохгүй байж, 2024 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс гаалийн албан татвараас чөлөөлөхөөр шийдвэрлэсэнтэй холбоотойгоор гурилын импорт 63.6 мянган тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 6 дахин нэмэгдлээ.

73. Ипотекийн зээлийн эх үүсвэр нэмэгдэж, цементийн гаалийн албан татварыг бууруулснаар барилгын материалын импорт өслөө. Барилгын салбарын үйлдвэрлэл 2024 онд 7.8 хувиар өссөн ба барилгын материалын импорт 1,326 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15 хувиар өслөө. Хуримтлалын сангаас 0.5 их наяд төгрөгийг ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт оруулж, ипотекийн зээлийн


үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 1.8 их наяд төгрөгөөр өссөнөөр орон сууцны эрэлт өсөж, барилгын материалын импортыг нэмэгдүүллээ. Барилгын үнийн хөөргөдлөөс сэргийлэх хүрээнд цементийн импортод хугацаа, хэмжээний хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэж, Засгийн газрын 2024 оны 188 дугаар тогтоолоор 2024 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл цементийн гаалийн албан татварыг 20 хувиас 5 хувь болгож бууруулсан.

74. Замын-Үүд боомтын ачаа тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлж, ажлын цагийн горимд өөрчлөлт оруулснаар импортын барааны урсгал нэмэгдлээ. Замын-Үүд боомтоор нийт импортын бараа бүтээгдэхүүний 50 орчим хувь нь нэвтэрч байна. Монгол Улсын Засгийн газраас Замын-Үүд-Эрээн автозамын боомтыг 2024 оны 4 сарын 1-нээс 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 24 цагаар ажиллуулахаар шийдвэрлэсэн. Ийнхүү цагийн горимд өөрчлөлт орсноор Замын-Үүд боомтын ачаа тээврийн цогцолбороор 2024 оны 4 дүгээр сараас 8 дугаар сарын хооронд хил нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44 хувиар их нэмэгдэж нийт 135.3 мянганд хүрэв. Эдийн засгийн идэвхжил өндөр байгаа энэ үед нийлүүлэлтийн тасралтгүй байдлыг хангах нь бараа бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгахад чухал хүчин зүйл юм.


75. Худалдааны гол түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарснаар импортын барааны зардал бага түвшинд байв. Импортын дүн өмнөх оны мөн үеэс 2.4 тэрбум ам.доллароор өссөний 90 орчим хувийг тоо хэмжээ, 10 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлсэн байна (Зураг 4.2). Худалдааны гол түнш орнуудын үнийн өсөлт саарснаар импортын барааны үнийн өсөлт бага түвшинд байв. Тухайлбал, манай улсын нийт импортын 40 хувийг бүрдүүлж буй БНХАУ-ын инфляц 2024 онд дунджаар 0.2 хувь байв. Харин нийт импортын 25 хувийг бүрдүүлж буй ОХУ-ын инфляц 2024 онд дунджаар 8.4 хувь байв. Гэвч тус улсаас импортолж буй бүтээгдэхүүний 70 хувийг нефтийн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа ба үүний 22 нэгж хувийг АИ-92 автобензин, 45 нэгж хувийг дизелийн түлш бүрдүүлж байна. ОХУ-ын Роснефть компанитай 2022 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу АИ-92 шатахууныг тогтвортой үнээр худалдан авч байгаа бөгөөд ОХУ-ны дизелийн түлшний үнэ буурч байгаа нь импортын барааны үнийн өсөлт бага байхад нөлөөллөө. Түүнчлэн нийт импортын 10 хувийг бүрдүүлж буй Япон улсаас автомашин, түүний сэлбэг давамгайлсан бараа бүтээгдэхүүн худалдан авч байгаа бөгөөд Япон иений ам.доллартой харьцах ханш буурснаар тус улсаас худалдан авч буй барааны зардлыг буурууллаа.

Зураг 4.2. Импорт

1.Импортын жилийн өсөлт (нэгж хувь)



2.Импортын өөрчлөлт (сая ам.доллар)



3.Импортын голлох бүтээгдэхүүн (сая ам.доллар)

Бүтээгдэхүүн	2023	2024	Өсөлт
Хүнс	977	1,169	19.7%
Суудлын автомашин	675	1,062	57.3%
Ачааны машин	433	722	66.7%
Барилгын материал	1,158	1,326	14.5%
Тоног төхөөрөмж	1,630	2,284	40.1%
Шатахуун	1,632	1,939	18.8%
Нийт	9,256	11,612	25.5%

Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

4.2. Төлбөрийн тэнцэл

76. Урсгал дансны тэнцэл алдагдалтай гарсан ч гадаад бондын орох урсгал нэмэгдсэнээр 2024 онд төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа. Импортын өсөлтийн нөлөөгөөр барааны худалдааны ашиг 2024 онд өмнөх оноос 1.6 тэрбум ам.доллараар буурснаар урсгал дансны тэнцэл 2.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа. Нөгөө талаас гадаад зах зээлд гаргасан шинэ бондуудын орох урсгал нэмэгдсэн нөлөөгөөр санхүүгийн дансны ашиг 3.2 тэрбум ам.доллараар нэмэгдсэнээр төлбөрийн тэнцэл 2024 онд 0.6 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

77. Ачаа тээврийн үйлчилгээний зардал буурах хандлагатай байгаа нь үйлчилгээний дансны алдагдлын өсөлтийн саарахад эергээр нөлөөлж байна. Монгол Улс 2024 онд үйлчилгээний экспортоор 1.6 тэрбум ам.долларыг хүлээн авч, гадаад улсад 4.6 тэрбум ам.долларын төлбөрийг төлсөн байна. Үйлчилгээний импортын жилийн өсөлт 2022 онд 1.0 тэрбум ам.доллар байсан бол 2024 онд 0.4 тэрбум ам.доллар болж саарлаа. Үүнд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй ашигт малтмалыг хил үнээр борлуулах, экспортын тээврийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээний үр дүнд ашигт малтмалын экспортын тээврийн зардал буурсан нь нөлөөллөө. Тухайлбал, цар тахлаас бусад жилд 2015 оноос хойш жил бүр дунджаар 0.2 тэрбум ам.доллараар нэмэгдэж ирсэн ашигт малтмалын экспортын тээврийг хамардаг ачаа тээврийн зардал сүүлийн 2 жил дараалан буурч, 2024 онд 2022 онтой харьцуулахад 0.1 тэрбум ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

78. Боловсролын үйлчилгээний төлбөрийн өсөлт өндөр байв. Монгол Улс 2024 онд аялал жуулчлалын үйлчилгээний худалдаагаар 0.6 тэрбум ам.долларыг хүлээн авч, гадаад улсад 1.6 тэрбум ам.долларын төлбөрийг төлсөн байна. Аяллын үйлчилгээний зардал цар тахлын дараа

2021-2023 оны дунджаар 0.2 тэрбум ам.доллараар өссөн бол 2024 онд өмнөх оноос 0.3 тэрбум ам.доллараар өссөн байна. Хэдийгээр 2024 онд аялал жуулчлалын зардал өссөн хэдий ч өмнөх онуудын дундаж өсөлттэй харьцуулахад боловсролын төлбөрийн өсөлт өндөр байв. Тухайлбал, 2024 онд хувийн аяллын зардал өмнөх 3 жилийн дунджаас 48 хувиар их буюу 0.2 тэрбум ам.доллараар өссөн бол боловсролын төлбөр өмнөх 3 жилийн дунджаас 2.1 дахин их буюу 0.1 тэрбум ам.доллараар өссөн байна.

79. Шууд хөрөнгө оруулалтын өсөлтийн дийлэнхийг уул уурхайн салбар бүрдүүллээ. Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалт 2024 онд 4.0 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 0.5 тэрбум ам.доллараар буюу 13 хувиар өслөө. Улсын бүртгэлд бүртгэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компанийн тоо 2024 онд өмнөх оноос 1.8 дахин нэмэгдэж, 485-т хүрсэн байна. Шууд хөрөнгө оруулалтыг салбараар харвал, уул уурхайн салбарын шууд хөрөнгө оруулалт өмнөх оноос 0.4 тэрбум ам.доллараар өссөн бол уул уурхайн бус салбарын шууд хөрөнгө оруулалт ердөө 41 сая ам.доллараар нэмэгджээ. Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, худалдаа, санхүү болон даатгалын салбаруудын хөрөнгө оруулалт буурсан бол хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа эрчим хүч, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа, боловсруулах салбаруудын хөрөнгө оруулалт өмнөх оноос өслөө.

80. Монгол Улс 2024 онд гадаад зах зээлд идэвхтэй бонд арилжааллаа. 2024 оны эхний хагаст "МИК ОССК" ХХК 225 сая ам.долларын бонд, Монгол Улсын Хөгжлийн банк 200 сая ам.долларын бонд, Голомт банк 300 сая ам.долларын бондыг арилжаалсан бол 2024 оны сүүлийн хагаст Худалдаа хөгжлийн банк 350 сая

ам.долларын бонд, нийслэл Улаанбаатар хот 500 сая ам.долларын бонд арилжаалсан нь гадаад валютын орох урсгалыг дэмжлээ. Мөн Монгол Улсын Засгийн газар 2017 онд гаргасан 600 сая ам.долларын Хуралдай бондын үлдэгдэл төлбөрийг 2024 оны 3 дугаар сард амжилттай төлж барагдууллаа.

81. Монголбанк своп хэлцлийн төлбөрийн төлөв. Монголбанк 2024 оны 2 дугаар улиралд Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн 4.5 тэрбум юань буюу 0.6 тэрбум ам.долларын эргэн төлөлтийг хийсэн нь гадаад валютын гарах урсгалыг нэмэгдүүлэв. Ингэснээр тус своп хэлцлийн үлдэгдэл 6.0 тэрбум юань буюу 0.8 тэрбум ам.доллар болж буурлаа.

Зураг 4.3. Урсгал дансны тэнцэл, гадаад валютын нөөц, төгрөгийн ханш



82. Гадаад валютын нөөц 2024 оны эцэст өсөж, төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш чангарлаа. Гадаад валютын улсын нөөц 2024 оны эцэст 5.5 тэрбум ам.доллар буюу бараа, үйлчилгээний импортын 4.1 сарын хэрэгцээг хангах түвшинд хүрлээ. Гадаад валютын нөөц оны эцэст өсөхөд нийслэлийн шинэ гадаад бондтой холбоотой гадаад валютын урсгал голлон нөлөөллөө. Монголбанк 2024 онд өмнөх оноос 33.1 хувиар буюу 2.7 тэрбум ам.доллараар их 6.6 тэрбум ам.долларыг зах зээлд дуудлага худалдаагаар нийлүүллээ. Төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн ханш 2024 оны эцэст 3,420 төгрөгт хүрч оны эхнээс 10 төгрөгөөр суларсан бол 2024 оны дундаж ханш 3,390 төгрөгт хүрч, өмнөх оны дунджаас 76 төгрөг буюу 2.2 хувиар чангарлаа. Худалдааны түнш орнуудын валютаар жигнэсэн төгрөгийн нэрлэсэн ханшийн индекс 2024 оны эцэст өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар чангарлаа. Харин дотоод үнийн өсөлт эрчимжиж, бодит ханш 2024

оны эцэст өмнөх оны мөн үеэс 9.8 хувиар чангарлаа.

83. Хэрэглээний өсөлтөөс шалтгаалсан хадгаламжийн бууралт урсгал дансны тэнцэл буурахад нөлөөллөө. Урсгал дансны тэнцлийг тухайн улсын нийт хадгаламж болон хөрөнгө оруулалтын зөрүүгээр мөн тайлбарладаг. Сүүлийн 10 жилийг авч үзвэл манай улсын хөрөнгө оруулалтын хэрэгцээ хадгаламжаас давж, 2023 оноос бусад онд урсгал данс алдагдалтай гарсан байна. Тухайлбал, ДНБ-д харьцуулсан урсгал дансны тэнцэл 2024 онд өмнөх оноос 9.9 нэгж хувиар буурч, -9.3 хувьтай тэнцэхэд ДНБ-д харьцуулсан хувийн хэрэглээ өмнөх оноос 9.1 нэгж хувиар буурч, нийт хадгаламж өмнөх оноос 8.9 нэгж хувиар буурсан нь голлон нөлөөллөө.


84. Гадаад хөрөнгө оруулалтын позиц сул хэвээр байна. Гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө болон Монгол Улс бусад улсад төлөх үүрэг бүхий

өр төлбөрийн зөрүүг харуулдаг гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2024 оны эцэст -43.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос буурсан ч ДНБ-д харьцуулсан дүнгээр 5 жил дараалан сайжирч, -184 хувьд хүрлээ. 2024 оны байдлаар Монгол улсад байршиж буй гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн 53.2 тэрбум ам.долларт хүрч, гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгөөс 5.4 дахин их байна. Гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 62 хувь буюу 33.1 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, 26 хувь буюу 14.0 тэрбум ам.доллар нь зээл

байна. Харин гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 56 хувь буюу 5.5 тэрбум ам.доллар нь нөөц хөрөнгө, 22 хувь буюу 2.1 тэрбум ам.доллар нь бэлэн мөнгө ба харилцах байна. Шууд хөрөнгө оруулалтыг хассан дүнгээр тооцвол Монгол улсын гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2024 оны эцэст ДНБ-ий -49 хувь болж, 2020 оноос 55 нэгж хувиар сайжирсан байна. Цаашид урсгал дансны алдагдлыг хязгаарлах, гадаад валютын нөөцийг зузаатгах замаар гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позицыг сайжруулж, гадаад шокт өртөх эмзэг байдлыг бууруулах шаардлагатай.


Зураг 4.4. Урсгал данс ба гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц

1.Урсгал дансны тэнцэл
(ДНБ-д эзлэх хувь)




Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

2.Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц
(ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

3.Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц (ШХО-ыг оруулаагүй)
(ДНБ-д эзлэх хувь)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик

Тэмдэглэл: ДНБ-д эзлэх хувийг 4 улирлын нийлбэрээр тооцов.

4.3. Гадаад өр

85. Нийт гадаад өрийн үлдэгдлийн дүн өссөн ч ДНБ-д эзлэх хувь буурлаа. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2024 оны эцэст 37.1 тэрбум ам.доллар болж, өмнөх оноос 2.5 тэрбум ам.доллароор буюу 7.4 хувиар өслөө. Харин ДНБ-ий өсөлттэй холбоотойгоор ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ 157.4 хувь болж, өмнөх оноос 12.7 нэгж хувиар буурсан байна. Гадаад өрийн үлдэгдлийн дүн нэмэгдэхэд шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл өмнөх оноос 2.2 тэрбум ам.доллароор өссөн нь голлон нөлөөллөө.


86. Хувийн хэвшлийн гадаад санхүүжилт нэмэгдлээ. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл 2024 онд өмнөх оноос 3.5 тэрбум ам.доллароор өслөө. Салбараар харвал, өмнөх онтой харьцуулахад 2024 онд уул уурхайн салбарын гадаад өрийн үлдэгдэл 2.1 тэрбум ам.доллароор, санхүү болон даатгалын салбарын гадаад өрийн үлдэгдэл 1.3 тэрбум ам.доллароор, тээврийн салбарын гадаад өрийн үлдэгдэл 0.2 тэрбум ам.доллароор тус тус өссөн байна. Санхүүгийн салбарын гадаад өр өсөхөд арилжааны банкууд 2024 онд гадаад зах зээлд шинэ бондууд арилжаалсан нь нөлөөллөө.

87. Гадаад валютын нөөц тогтворжсон нь төв банк своп хэлцлийн өрийг бууруулах боломжийг бий болгов. Гадаад валютын нөөц 2024 оны эхний улиралд 5.2 тэрбум ам.долларт хүрч нэмэгдсэнээр Монголбанк 2024 оны 2 дугаар улиралд Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн 4.5 тэрбум юанийн эргэн төлөлтийг гүйцэтгэх боломжийг бүрдүүлээ. Улмаар төв банкны гадаад өр өмнөх оноос 0.7 тэрбум сая ам.доллароор буюу 39 буурлаа.


88. Манай улсын гадаад өрийн дийлэнхийг шууд хөрөнгө оруулалт болон зээл бүрдүүлж байна. Нийт гадаад өрийн үлдэгдлийн 46 хувь буюу 17.3 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалттай компанийн өглөг, 38 хувь буюу 14.0 тэрбум ам.доллар нь зээл байна. Зээлийн үлдэгдлийн 54 хувийг Засгийн газар болон төв банк, 46 хувийг хувийн хэвшил бүрдүүлж байна. Цаашид макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангаж, зээлжих зэрэглэлийг үргэлжлүүлэн ахиулж, гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, өртгийг бууруулах шаардлагатай.

Зураг 4.5. Гадаад өр


1.Гадаад өр
(ДНБ-д эзлэх хувь)



2.Гадаад өрийн жилийн өөрчлөлт
(сая ам.доллар)



3.Гадаад өр, 2024 он
(сая ам.доллар)



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол, Монголбанкны статистик
Тэмдэглэл: ДНБ-д эзлэх хувийг 4 улирлын нийлбэрээр тооцов.

Бүлэг 5

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

5.1. Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

5.2. Түүхий эдийн зах зээлийн хандлага

5.3. Олон улсад 2024 онд зарлагдсан индексүүд

5. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ ТОЙМ

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2024 онд 3.3 хувьд хүрсэн хэдий ч геополитикийн тогтворгүй байдал, худалдааны дайны өрнөлтэй холбоотойгоор дэлхийн дахинд тодорхой бус байдал өндөр байна.

5.1. Дэлхийн эдийн засаг

89. Дэлхийн эдийн засгийн өсөлт тогтворжив.

Цар тахал, үнийн өсөлт, геополитикийн тогтворгүй байдал зэрэг сүүлийн жилүүдэд тохиосон хүндрэлүүдийн нөлөө саарч, дэлхийн эдийн засаг 2024 онд 3.3 хувиар өслөө. Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлт цар тахлаас өмнөх 2000-2019 оны түүхэн дундаж өсөлт болох 3.7 хувиас бага байна. Өнгөрсөн онд дэлхийн бараа, үйлчилгээний худалдааны өсөлт 3.8 хувьд хүрч өмнөх оноос 2.8 нэгж хувиар өссөн бол дундаж инфляц 2024 онд 5.7 хувьд хүрч, өмнөх оноос 1 нэгж хувиар буурсан байна.

90. Дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал өндөр байна.

Хэдийгээр өнгөрсөн 2024 онд дэлхийн эдийн засаг тогтворжих хандлага ажиглагдсан ч 2025 он эхэлснээс хойш эрчимтэй өрнөж буй геополитикийн тогтворгүй байдал, худалдааны дайны нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн тодорхой бус байдлын индекс (World Uncertainty Index)-ийн үзүүлэлтээр дэлхийн тодорхой бус байдал цар тахлын дараах хамгийн өндөр түвшинд хүрээд байна. Үүнтэй холбоотойгоор ОУВС дэлхийн эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг 3.3 хувиас 2.8 хувь, 2026 оны өсөлтийн төсөөллийг 3.3 хувиас 3.0 хувь болгож, 2025 оны 1 дүгээр сард зарласан төсөөллөөс тус тус 0.5 нэгж болон 0.3 нэгж хувиар бууруулаад байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр тэлж болзошгүй байгаа нь дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн, БНХАУ-ын үл хөдлөх салбарын уналт, ОХУ-Украины дайн болон Ойрхи Дорнодын тогтворгүй байдал зэрэг эдийн засаг, геополитикийн тогтворгүй байдал зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж болзошгүй байна.

91. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарав.

БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 5.0 хувь

гарч, тус улсын засгийн газрын зорилтот түвшинд хүрсэн хэдий ч үл хөдлөх хөрөнгийн салбар уналттай, дотоод эрэлт сул хэвээр байгаа нь эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг ОУВС 2025 болон 2026 онд 4 хувь байх төсөөллийг 2025 оны 4 дүгээр сард зарлаад байна. Гэсэн хэдий ч худалдааны дайнтай холбоотой тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь БНХАУ-ын эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж байна.

92. Евро бүсийн эдийн засаг 2024 онд 0.8 хувиар тэллээ.

Бүсийн эдийн засгийн 30 орчим хувийг бүрдүүлдэг ХБНГУ-ын аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна. Худалдааны дайнтай холбоотойгоор эдийн засгийн өсөлт 2025 онд 0.8 хувьд хадгалагдах бол 2026 онд бодит цалингийн өсөлт, ХБНГУ-ын төсвийн тэлэлтийн нөлөөгөөр бүсийн өсөлт 1.2 хувьд хүрч эрчимжинэ гэж ОУВС тооцоолж байна.

93. Хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2024 онд 2.8 хувиар тэллээ.

Үнийн өсөлт болон хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалтай уялдуулан Холбооны нөөцийн банк бодлогын хүүг 2024 онд 3 удаа бууруулаад байна. Худалдааны дайн, бодлогын тодорхой бус байдал болон эрэлт буурах төлөвөөс шалтгаалан ОУВС тус улсын эдийн засгийн 2025 оны өсөлтийн төсөөллийг 1.8 хувь, 2026 оны өсөлтийн төсөөллийг 1.7 хувь болгож, өмнөх төсөөллөөс тус тус 0.9 нэгж хувь болон 0.4 нэгж хувиар бууруулаад байна. Тус улсын өрнүүлж буй худалдааны дайны цар хүрээ улам бүр нэмэгдэж байгаа нь АНУ төдийгүй дэлхийн худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал хумигдах, инфляц өсөх эрсдэлийг нэмэгдүүлж байна

5.2. Түүхий эдийн зах зээл

94. Зэс, алтнаас бусад голлох түүхий эдийн үнэ 2024 онд буурлаа. Өнгөрсөн жилүүдэд Ковид-19 цар тахал, Украин дэх цэргийн үйл ажиллагаа, ойрх дорнод дахь мөргөлдөөн, гадаад улсуудын өндөр инфляцын зэргүүд нь глобал орчинд тогтворгүй байдлыг бий болгож, түүхий эдийн үнэ өндөр хэлбэлзэлтэй байлаа. Харин 2024 онд дэлхийн эдийн засаг тогтворжиж, голлох түүхий эдийн нийлүүлэлт нэмэгдсэнээр зэс, алтнаас бусад голлох түүхий эдийн үнэ буурлаа.

95. Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн дундаж үнэ 2024 онд 9,145 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 8.8 хувиар өссөн байна. Томоохон зэсийн уурхайнууд олборлолтоо бууруулж, зардлаа багасгаж эхэлснээр богино хугацаанд нийлүүлэлтийн тогтворгүй байдал бий болж зэсийн үнэ өсөхөд голлон нөлөөллөө. Цаашид, цахилгаан автомашин, сэргээгдэх эрчим хүчний салбарын өсөлтөөс шалтгаалан эрэлт зэсийн эрэлт нэмэгдэж үнэ өсөхөөр байна.

96. Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2024 онд 243 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 26.3 хувиар буурсан байна. Индонези, Австрали, Өмнөд Африк зэрэг томоохон нүүрс экспортлогч орнууд олборлолтоо нэмэгдүүлснээс гадна Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбар үргэлжлүүлэн хямарсаар байгаа нь коксжих нүүрсний үнэ буурахад голлон нөлөөллөө. Цаашид, дэлхийн зах зээл дэх коксжих нүүрсний нийлүүлэлт нэмэгдэх төлөвтэй байгаагаас гадна Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал

сэргэх төлөвгүй байгаа тул коксжих нүүрсний үнэ буурахаар байна.

97. Лондоны металлын бирж дэх Алтны дундаж үнэ 2024 онд 2,389 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 23.0 хувиар өссөн байна. АНУ-ын холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ 2024 онд хэд хэдэн удаа бууруулсан алтны эрэлтийг нэмэгдүүлж улмаар үнэ өслөө. Цаашид, геополитикийн эрсдэл өндөр байгаа энэ орчинд алтны үнэ үргэлжлүүлэн өсөхөөр байна.

98. 62 хувийн агууламжтай төмрийн баяжмалын дундаж үнэ 2024 онд 110 ам.доллар/тонн болж, өмнөх оны эцсээс 8.0 хувиар буурсан байна. Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлт нэмэгдсэн, Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбар сэргэж чадахгүй байгаа зэрэг нь төмрийн баяжмалын үнэ буурахад голлон нөлөөллөө. Цаашид, Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал сэргэх төлөвгүй байгаагаас гадна Австрали, Бразил зэрэг улсуудын олборлолт тогтвортой өсөхөөр байгаа тул төмрийн баяжмалын үнэ буурахаар байна.


99. Брент төрлийн газрын тосны дундаж үнэ 2024 онд 75 ам.доллар/баррель болж, өмнөх оны эцсээс 1.3 хувиар буурсан байна. АНУ, Канад, Бразил улсууд дахь газрын тосны олборлолт нэмэгдсэнээс гадна Хятадын эдийн засгийн өсөлтийн удаашрал зэрэг нь газрын тосны үнэ буурахад голлон нөлөөллөө. Цаашид, Хятадын эдийн засгийн өсөлтийн удаашралаас шалтгаалан газрын тосны үнэ буурахаар байна.

5.3. Олон улсад зарлагдсан индексүүд

100. Авлигын төсөөллийн индекс:

Монгол Улс 2024 онд Авлигын төсөөллийн индексээр⁷ дэлхийн 180 орноос 114 дүгээрт жагсаж, өмнөх оноос 5 байраар урагшиллаа. Панам, Филиппин, Египет, Эквадор зэрэг улсын үнэлгээ дунджаар 2.1 оноо буурснаар манай улс авлигын үзүүлэлтээр эдгээр улсуудын өмнө эрэмбэлэгдэж байр ахих гол шалтгаан болжээ.

Монгол Улс 2024 онд Авлигын төсөөллийн индексээр 33 оноо авсан нь дэлхийн дунджаас 10 оноо, бүс нутгийн дунджаас 12 оноогоор бага байгаа бөгөөд 10 жилийн өмнөх үнэлгээтэй харьцуулахад 6 оноо буурч, эрэмбэ 34 байраар ухраад байна (Зураг 5.3).



Авлигыг шууд хэмжихэд хүндрэлтэй байдаг тул санал асуулга, шинжээчдийн үнэлгээгээр авлигын төсөөлж буй түвшинг хэмждэг билээ. Иймд авлигын асуудлууд олон нийтэд ил болох үед индексийн үнэлгээ буурах үзэгдэл ажиглагдаж болох талтай. Тухайлбал, 2018 онд оффшор дансны хэрэг, 2020 онд ЖДҮХС-ийн хэрэг, 2023 онд нүүрсний хулгайн хэрэг олон

нийтийн дунд шуугиан тарьсан үед авлигын индекс тус тус 2 оноогоор буурч байжээ.

Авлигын төсөөллийн индексийн Монгол Улсын үнэлгээг 8 эх сурвалж бүхий судалгаа, тайлангийн авлигатай холбоотой хэсгийн үнэлгээгээр дундажлан тооцсон байна. Эх сурвалж бүрээр харвал авлигын хяналт, хариуцлага тооцох тогтолцоо /Шилжилтийн индекс, Бертельсманн сан/, гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх байгууллагын албан хаагчдын авлига /Төрийн зарчимт ёсны индекс, Шударга ёсны төсөл/, улс төрийн авлигын түвшин /Олон улсын эрсдэлийн тайлан, PRS групп/ гэсэн үзүүлэлтийн үнэлгээ сайжирчээ. Харин шүүхийн шийдвэр, үйл явцад нөлөөлөх зорилготой аливаа төлбөр, хахууль өгөх байдал /Ардчиллын индекс, V-Dem/, авлигын дарамт, төсвийн хөрөнгө завших /Удирдах албан тушаалтны санал асуулга, Дэлхийн эдийн засгийн форум/, улс төрөөс хараат бус байдал /Улс орнуудын эрсдэлийн үнэлгээ, EIU/, авлига байдаг эсэх /Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан, IMD/, авлигын дарамт буюу бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд авлига нэхэх нөхцөл байдал /Бизнес орчин, эрсдэлийн үнэлгээний тайлан, S&P/ гэсэн үзүүлэлтүүдийн үнэлгээг бууруулсан байна. Үүнээс дүгнэвэл авлигатай тэмцэх институтийн зохицуулалт, хариуцлагын тогтолцоонд ахиц гарсан ч бизнесүүдэд тулгардаг авлигын дарамт, шүүхийн хараат бус байдлаар бодит үр дүн хараахан гараагүй байна гэж дүгнэж болохоор байна. Гэсэн хэдий ч манай улсын үнэлгээний хувьд зарим эх сурвалжийн онооноос зөрөх⁸, зарим үзүүлэлтийн дата мэдээлэл олон нийтэд нээлттэй тавигдаагүй

⁷ Транспаренси Интернэшнл олон улсын байгууллагаас тооцоолон гаргадаг тус индекс нь дэлхийн улс орнуудын төсвийн зарцуулалт, эрх мэдлээ урвуулан ашиглах байдал, авлигын гэмт хэрэгт хариуцлага тооцох тогтолцоо зэрэг үзүүлэлтийг 13 орчим эх сурвалжийн судалгаа, тайланд үндэслэн тооцдог байна. Тус индексийг 0-100 онооны хооронд үнэлж гаргадаг бөгөөд индекс 100-д ойртох тусам авлигын төсөөлж буй түвшин бага, 0-д ойртох тусам авлига их байна гэж үздэг.

⁸ Бертельсманн сангийн Шилжилтийн индекс дэх авлигын хяналт, хариуцлага тооцох тогтолцооны үзүүлэлтийн үнэлгээ дээшилсэн, харин S&P-ийн Бизнес орчин, эрсдэлийн үнэлгээний тайлангийн авлигын дарамтын үнэлгээ буурсан гэж үнэлэгдсэн ч эдгээр индексүүдийн авлигатай холбогдох асуултуудын үнэлгээ өмнөх оноос өөрчлөгдөөгүй байна.

байх⁹ нь индексийг илүү нарийвчлан харж дүгнэлт хийхэд хязгаарлалт болж байгааг дурдах нь зүйтэй.

Индекс тооцсон улсуудын 2/3 нь 50-аас бага үнэлгээ авч, авлигын асуудал дэлхий дахинд тулгамдсан асуудлын нэг болж байна. Баруун Европ, Европын Холбооны улсууд авлигын үзүүлэлтээр сайн үнэлэгддэг ч 2024 онд бүс нутгийн дундаж оноо өмнөх оноос 1 оноогоор буурч 64 болжээ. Харин Саб-Сахарын Африкын улсууд авлигын үзүүлэлтээр хамгийн сул (33 оноо) байна. Америк тив (42 оноо), Ази номхон далайн бүс (44 оноо), Зүүн Европ, Төв Ази (35 оноо), Ойрх дорнод, Хойд Африк (39 оноо)-т авлигын үзүүлэлт мөн л ахицгүй, бүс нутгийн дундаж оноо буурах хандлага ажиглагдаж байна. Иймд Авлигын эсрэг тэмцлийг тэргүүлэх, урт хугацааны зорилт болгож, тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Транспаренси Интернэшнлээс улс орон, олон улсын байгууллагуудад уриалжээ.

Улсаар авч үзвэл, дэлхийд авлигын үзүүлэлтээр тэргүүлэгч байр сууриа Европын Холбооны улсууд болон Сингапур улс хадгалсаар байна. Европын Холбооны улс орнуудад төрийн үйл ажиллагааны ил тод байдал, олон нийтийн хяналт илүү хөгжсөн байх бол Сингапурт хатуу ялын бодлогыг авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж байна. Харин зэвсэгт мөргөлдөөний нөхцөл байдалд байгаа Өмнөд Судан, Сомали, Венесуэл, Сири, Йемен зэрэг улсууд индексээр сүүл мушгиж байна.

101. Хуулийн засаглалын индекс:

Дэлхийн шударга ёсны төслөөс жил бүр гаргадаг Хуулийн засаглалын индекс¹⁰ (Rule of Law Index)-ээр Монгол Улс 2024 онд үнэлгээнд хамрагдсан

⁹ Авлигын төсөөллийн индексийн аргачлалд EIU-ийн Улс орнуудын эрсдэлийн үнэлгээнд төсвийн зарцуулалт, ил тод байдал, төсвийн хараат бус байдал, шүүх, төрийн албаны томилгооны улс төрөөс хараат бус байдал, хахуулийн түвшин зэрэг 8 үзүүлэлтийн үнэлгээг ашигладаг талаар дурдсан хэдий ч тус дата, мэдээлэл олдоогүй болно.

142 улсаас 66 дугаарт эрэмбэлэгдэж 2 байр ухарлаа. Хэдийгээр манай улсын зарим үзүүлэлт бага зэрэг сайжирч, оноо өмнөх онтой ижил 0.53 үнэлэгдсэн ч бусад улс илүү сайжирсны улмаас манай улсын эрэмбэ ухарсан байна.

Монгол Улсын үнэлгээг индексийн бүлэг тус бүрээр доорх хүснэгт (Хүснэгт 3)-д харуулав.

Хүснэгт 5. Хуулийн засаглалын индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ, бүлгээр

Бүлэг	2023		2024	
	Оноо	Байр	Оноо	Байр
Засгийн газрын эрх мэдлийн хязгаарлалт	0.53	#71	0.53	#69▲
Авлигагүй байдал	0.42	#86	0.43▲	#83▲
Засгийн газрын нээлттэй байдал	0.49	#74	0.49	#73▲
Үндсэн эрх	0.56	#69	0.56	#69=
Хэв журам ба аюулгүй байдал	0.76	#58	0.76	#58=
Зохицуулалтын хэрэгжилт	0.48	#79	0.49▲	#75▲
Иргэний шударга ёс	0.54	#66	0.54	#65▲
Эрүүгийн шударга ёс	0.48	#58	0.48	58=
Нэгдсэн индекс	0.53	#64	0.53	#66▼

Засгийн газрын эрх мэдлийн хязгаарлалт бүлэг өмнөх оны адил 0.53 оноо авсан ч өмнөх оны үзүүлэлтээс 2 байр урагшлан 69 дүгээрт эрэмбэлэгдлээ. Тус бүлгийн үзүүлэлтийг задалж харвал төрийн албан хаагчид ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоо өмнөх үеэс сайжирсан гэж дүгнэжээ. Энэ хүрээнд хийгдсэн томоохон ажлаас дурдвал Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдөр батлан

¹⁰ Хуулийн засаглалын индексийг нийт 0-1 онооны хооронд үнэлдэг бөгөөд индекс 1-д ойртох тусам хууль дээдлэх байдал сайн, 0-д дөхөх тусам хууль дээдлэх байдал сул гэж үздэг.

хэрэгжүүлж байгаа нь төрийн албан хаагчид нийтлэг мөрдөх ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг тогтоож, түүнийг сахин мөрдүүлэх, хэрэгжүүлж хэвшүүлэх механизмыг бий болгох суурийг тавьсан. Засгийн газрын нээлттэй байдал бүлэг мөн адил өмнөх онтой ижил 0.49 оноо авч, 1 байр урагшлан 73 дугаарт эрэмбэлэгджээ. Тус бүлгээр хууль тогтоомж, засгийн газрын мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлэх, мэдээлэл авах эрх, иргэний оролцоо, гомдлын механизмууд гэсэн үзүүлэлтүүдийг хэмждэг байна.

Тайлант онд оноо ахисан бүлэгт Авлигагүй байдал болон Зохицуулалтын хэрэгжилт бүлэг орсон байна. Авлигагүй байдал бүлэг өмнөх оны үзүүлэлтээс 0.1 оноо ахиж 0.42 оноо авснаар 83 дугаарт эрэмбэлэгдэн 3 байр урагшилсан байна. Үүнд төрийн албан хаагчид албан тушаалаа урвуулан ашиглах явдал буурсан нь эергээр нөлөөлсөн гэж дүгнэжээ. Зохицуулалтын хэрэгжилт бүлэг 0.49 оноогоор 75 дугаарт эрэмбэлэгдэж 4 байр ахисан үзүүлэлттэй байна. Бүлгийн үзүүлэлтээр задлан харвал засгийн газрын зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, захиргааны шийдвэр гаргалтад удаашралгүй ажиллах гэсэн үзүүлэлтүүдээр дэлхийн дунджаас өндөр үнэлгээтэй байна. Мөн төрийн зохицуулалтыг ямар нэг нөлөөлөлгүйгээр шууд хэрэгжүүлж буй байдал сайжирсан, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим өөрчлөлтүүд, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг үндэслэлгүйгээр

хойшлуулах явдал буурсан нь эергээр нөлөөлсөн байна.

Оноо, байр хэвээр хадгалагдсан бүлгүүдийн тухайд үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг дээдлэх байдал, энэ нь бодит амьдрал дээр хэр хангагдаж байгааг хэмждэг Үндсэн эрх бүлэг 0.56 оноо, 69 дүгээр байрт, хувь хүний болон өмчийн аюулгүй байдал хэр хангагдаж байгааг хэмждэг Хэв журам ба аюулгүй байдал бүлэг 0.76 оноо, 58 дугаар байрт, Эрүүгийн шударга ёс бүлэг 0.48 оноо, 58 дугаар байрт эрэмбэлэгдсэнээр оноо, байр хадгалагдлаа. Эрүүгийн шударга ёс бүлэгт засан хүмүүжүүлэх тогтолцоо гэмт хэргийн бууралтад эергээр нөлөөлөх байдал сайжирсан, хуулийн дагуу яллагдагчийн эрх сайжирсан нь ахиц авчирсан байна. Гэвч эрүүгийн тогтолцооны шударга ёс болон шүүн таслах ажиллагааны үр дүнтэй байдал буурсан, эрүүгийн тогтолцоо дахь авлигын түвшин, хараат бус байдал нэмэгдсэн нь сөрөг нөлөө үзүүлсэн гэж үнэлэгджээ.

Манай улс 2024 онд тус индексийн иргэний шударга ёс бүлэгт 0.54 оноо авч, 142 орноос 62-т эрэмбэлэгдсэн нь өмнөх оноос 1 байр ахисан үзүүлэлт боллоо. Энэ нь иргэний шударга ёс авлигаас ангид байдлын үзүүлэлт сайжирсантай холбоотой байна. Гэсэн хэдий ч иргэний хэргийн шийдвэрлэлт удааширч, иргэний шударга ёс төрийн зохисгүй нөлөөллөөс ангид байх зарчим сулран, хэрэгжилтийн үр нөлөө буурсан нь тухайн бүлгийн өсөлтийг хязгаарласан байна.

Шигтгээ 4. Бизнес эрхлэх орчны үнэлгээ

Бизнесийн орчныг үнэлдэг индексүүд нь улс орнуудын бизнес эрхлэх орчны чанарыг харьцуулж, сайжруулах шаардлагатай чиглэлийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг. Манай улс Дэлхийн банкнаас гаргадаг Бизнес эрхлэхүй (Doing Business)-н индексээр 2020 онд 190 орноос 81 дүгээр байранд эрэмбэлэгдсэн. Тус индекс 2020 оноос хойш дахиж зарлагдаагүй явсаар мэдээлэл цуглуулах хүрээг өргөтгөн, судалгаан дахь чанарын үзүүлэлтүүдийг нэмэгдүүлж 2024 оноос Бизнес бэлэн (B-Ready буюу Business Ready) нэрээр дахин зарлаж эхэлсэн (манай улсыг 2026 оноос үнэлнэ) байдаг. Бизнес эрхлэхүйн индексийн шалгуур үзүүлэлтүүдийг судалж үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 6. Бизнесийн эрхлэхүйн индексийн Монгол Улсын оноо, эрэмбэ, шалгуур үзүүлэлтээр

	Оноо	Байр	Децил
Бизнес эхлүүлэх	86.9	#100	VI
Барилгын зөвшөөрөл	78.2	#29	II
Эрчим хүч холболт	54.9	#152	IX
Өмч бүртгүүлэх	74.1	#50	III
Зээл авах	80	#25	II
Жижиг хөрөнгө оруулагчдын эрх ашгийн хамгаалал	68.3	#25	II
Татвар төлөлт	77.3	#71	IV
Гадаад худалдаа	66.9	#143	VIII
Гэрээний хэрэгжилт	61.4	#75	IV
Төлбөрийн чадваргүй байдал	29.4	#150	VIII
Нэгдсэн индекс	67.7	#81	V

Бизнес эхлүүлэх үзүүлэлтээр 190 орноос 100 дугаарт жагссан байна. Одоогийн байдлаар манай улсын хувьд шинэ бизнес бүртгүүлэхэд 7 үе шат дамжиж, 10 хоног зарцуулж байх бол 14 дүгээрт жагссан Эстони улс 3 үе шатаар 3.5 өдөрт бүртгүүлж байна.

Бизнес эхлүүлэхэд тулгардаг бэрхшээлийн нэг нь тусгай зөвшөөрөл авах үйл явц байдаг. Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг цахимжуулах ажил үргэлжлэн явагдаж тусгай зөвшөөрлийн нэгдсэн систем (www.license.mn)-д одоогоор 30 яам, агентлаг холбогдоод байгаа боловч зөвшөөрөл олгох хугацаа харилцан адилгүй байна. Тухайлбал, дунджаар Гаалийн ерөнхий газар 67 хоног, Эрүүл мэндийн яам 54 хоног, Боловсролын яам 49 хоног зарцуулж байна.

Эрчим хүчинд холбогдох үзүүлэлтээр Монгол Улс 190 орноос 152 дугаар байранд буюу IX децилд эрэмбэлэгдсэн нь манай улсын хувьд хамгийн сул үзүүлэлт болжээ. Бизнесүүд эрчим хүчинд холбогдоход одоогоор 8 үе шат дамжиж, дунджаар 51 хоног зарцуулж байна. Үүнээс гадна цахилгаан хангамжийн найдвартай байдал, цахилгаан тасалдал нь бизнесийн орчинд сөргөөр нөлөөлж байна.

Өмч бүртгүүлэх үзүүлэлтээр 190 орноос 50 дугаар байранд эрэмбэлэгдэж байна. Манай улсад үл хөдлөх хөрөнгийн бүртгэл 5 үе шатаар дамжин хийгдэж, 11 өдөр зарцуулдаг бол энэхүү үзүүлэлтээр 1 дүгээрт жагссан Катар улсын хувьд ганц шаттай, ганц л өдөр зарцуулдаг байна. Түүнчлэн газар өмчлөлийн мэдээллийн ил тод бус байдал, бүртгэлийн системийн уялдаа сул, гомдол гаргах хараат бус механизм байхгүй зэрэг нь оноо алдах хүчин зүйлс болжээ.

Зээл авахтай холбоотой үзүүлэлтээр 190 орноос 25 дугаар байранд буюу харьцангуй сайн үнэлгээтэй боловч зээлийн хүү өндөр байгаа нь томоохон асуудал болж байна. Зээлийн хүү өндөр байгаа шалтгаан нь зах зээл дээр илүүдэл мөнгө ихтэй, инфляц өндөр байгаатай холбоотой. Төв банк бодлогын хүүг бууруулахад илүүдэл мөнгө зах зээлд орж, инфляцын эрсдэл нэмэгддэг. Иймд зах зээл дээрх мөнгөний нийлүүлэлтийг хязгаарлах, төв банкны алдагдлыг бууруулах шаардлагатай байна.


Татварын орчны үзүүлэлтээр 190 орноос 71-т бичигдсэн. Татварын орлогын ДНБ-д эзлэх хувь хамгийн сүүлд шинэчилж зарлагдсан хугацаа буюу 2022 оны байдлаар Вьетнам, Казакстан зэрэг улсад 20 хувьд хүрэхгүй байх бол манай улсад 25 хувь, 2024 оны байдлаар 34 хувьд хүрч өссөн үзүүлэлттэй байна. Мөн татаас, дэмжлэгийн үр ашиггүй байдал зах зээлийн гажуудал үүсгэж, бизнесийн орчныг хязгаарлаж байна. Жишээлбэл, 2007 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлсэн 12 хөтөлбөрийн ихэнх нь анхны зорилгодоо хүрээгүй¹¹ гэж дурджээ.

Бизнес эрхлэхүйн индексийн гадаад худалдааны хэсэгт манай улс 190 орноос 143 дугаар байранд жагссан нь голчлон экспорт хийхэд хилийн зохицуулалтын шаардлага биелүүлэх хугацаа, баримт бичгийн шаардлага хангах хугацаа урт байгаа нь нөлөөлжээ. Экспортын бичиг баримт бүрдүүлэхэд 168 цаг, хил нэвтрэхэд 134 цаг, импортын бичиг баримт бүрдүүлэхэд 115 цаг зарцуулж байгаа талаар индексийн тайланд дурдсан байна.

¹¹ “Хөдөө аж ахуйн дэмжлэг, урамшууллын судалгааны тайлан”, НҮБХХ, 2023

Гэрээний хэрэгжилт үзүүлэлтээр 190 орноос 29 дүгээр байранд жагсаж байна. Уг хэсгийн шүүхийн процесстой холбоотой индекс хамгийн муугаар үнэлэгдсэн байна. Энэ нь тухайлбал, зөвхөн арилжааны хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн нэгжтэй эсэх, бага үнийн дүн бүхий нэхэмжлэлтэй хэргийг хялбараар шийдэх механизмтай эсэх, хэрэг шийдвэрлэх цахим арга хэрэгсэлтэй эсэх, шүүхийн автоматжуулалт зэрэг үзүүлэлтүүдтэй холбоотой байна. Иймд шүүхийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, хараат бус байдлыг сайжруулах шаардлагатай байна.

Төлбөрийн чадваргүйдлийг шийдвэрлэх үзүүлэлтээр манай улс хойгуур буюу VIII децилд жагсжээ. Тус тайланд шүүхээр дамжин бизнесийн зээл, авлага барагдуулахад 4 жил зарцуулдаг, маргаан шийдвэрлэх хугацаанд нийт зээл, авлагын 15 хувийг шүүхийн зардалд зарцуулж, зээл, авлагын 18.2 хувийг эргүүлэн олж авдаг нь бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулдаг байна.



Засгийн газрын хуралдааны 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 7 дугаар хуралдааны тэмдэглэл

Эдийн засаг, хөгжлийн яамнаас бизнесийн орчны үнэлгээг судалж Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулснаар дээр дурдсан зарим үзүүлэлтийг сайжруулах талаар тусгасан хуралдааны тэмдэглэл гарч холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгөгдөөд байна. Үүнд:

- Хуулийн этгээд байгуулах шат дамжлагыг цөөлж, цахимжуулах, ажлын 3 өдөрт багтаан ашгийн төлөө хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгэх;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх бизнесийн төрлийг цөөлж оновчтой тогтоох;
- Цахилгаан эрчим хүчинд холбогдох зөвшөөрөл олгох, холболт хийх хугацааг 40 хоногт багтаах;
- Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулж, үйл ажиллагааг www.license.mn-д нэгтгэх, цахимаар шийдвэр гаргах хугацааг тогтоох, төрийг үйлчилгээний нэгдсэн системд холбох;
- Төрөөс зах зээлд нөлөөлөх аливаа арга хэмжээг хэрэгжүүлэхийн

өмнө үр дүн, зорилттой уялдуулж үе шаттай хэрэгжилтийг дүгнэж, зогсоох стратеги (exit strategy)-ийг боловсруулдаг байх;

- Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт олгож байгаа татаас, дэмжлэгийн үр ашигт дүн шинжилгээ хийж, үе шаттайгаар багасгах, зогсоох талаар санал боловсруулах;
- ҮЦТХТ-өөс өмчлөх эрхийн тухайлсан бүртгэл, хадгаламжийн үйл ажиллагааг брокер, кастодианд шилжүүлэх боломжийг судлах.

Бүлэг 6

ЭРСДЭЛ

6. ЭРСДЭЛ

НЭГ. Худалдааны дайн АНУ-ын худалдааны бодлогын шийдвэрүүдтэй холбоотойгоор дэлхийн эдийн засагт тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Худалдааны дайны цар хүрээ улам бүр өргөжиж байгаа нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх, бодлогын хүү удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Улмаар энэ нь манай улсын экспортын орлого буурах, инфляц өсөх, гадаад санхүүжилтийн өртөг, зардал нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна.

ХОЁР. БНХАУ-ын эдийн засаг БНХАУ-ын эдийн засагт үл хөдлөх салбарын уналт үргэлжилж, дотоод эрэлт сул хэвээр байна. БНХАУ-ын засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа хэдий ч худалдааны дайны хүрээнд АНУ-ын зүгээс БНХАУ-аас импортолж буй бүтээгдэхүүнд өндөр тариф тогтоосноор хоёр улс хоорондын худалдааны дайн хурцдаж, цаашид улам бүр тэлэх эрсдэлтэй байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт төсөөллөөс доогуур байх нь манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй.

ГУРАВ. ОХУ-Украины дайн ОХУ-Украины дайнтай холбоотойгоор газрын тосны үнэ 2022 онд огцом өссөнөөр импортын зардал нэмэгдэж, дотоодын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт эрчимтэй явагдсан. Цаашид дайны нөхцөл байдал хурцдах нь нефтийн бүтээгдэхүүний үнийг өсгөж, инфляцын дарамтыг нэмэгдүүлж болзошгүй эрсдэл хэвээр байна. Мөн ОХУ-ын эсрэг Европын холбоо, Их Британи болон АНУ зэрэг улсуудын авч хэрэгжүүлж буй хориг арга хэмжээ нэмэгдэх нь манай улсын гадаад төлбөр тооцоо саатах эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй.

ДӨРӨВ. Уур амьсгалын өөрчлөлт Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор хөдөө аж ахуйн салбар сүүлийн 2 жил дараалан агшаад байна. Цаг агаарын таагүй нөхцөл байдлаас өндөр хамааралтай хөдөө аж ахуйн салбарт зудын эрсдэл нэмэгдэж, хаваржилт хүндрэх, зуншлага тааруу байх, ган тохиолдох, малын халдварт өвчин тархах эрсдэл өндөр байна. Энэ нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, өрхүүдийн орлого буурах, орлогын тэгш бус байдал нэмэгдэх, дотоодын хүнсний инфляц нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна.

ТАВ. Эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдал Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй, 20 орчим хувийг хөрш орнуудаас худалдан авч хэрэглэж байна. Түүнчлэн Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэл өссөн нэмэгдэж буй хэрэглээг хангаж чадахгүй байгаагийн зэрэгцээ станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Эрчим хүчний тасалдал нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

ЗУРГАА. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед манай улс аливаа төрлийн хоригт өртөхгүй байх, зээлжих зэрэглэлийг сайжруулах хүрээнд олон улсад баримталж буй дүрэм журмуудыг мөрдөж, зээлжих зэрэглэл тогтоодог болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх нь зүйтэй байна. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

Хавсралт

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024
БОДИТ СЕКТОР					
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	37,453	43,555	53,852	70,442	79,956
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	-4.6	1.6	5.0	7.4	4.9
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	-4.4	1.6	5.0	7.2	5.0
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	-12.6	17.6	11.4	5.4	21.4
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	-2.7	-7.5	13.9	18.0	0.5
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	11.0	-8.5	-20.3	-16.2	-16.8
Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)					
Эцсийн хэрэглээ	3.6	-2.3	6.5	7.0	12.1
Өрхийн хэрэглээ	1.3	-4.0	5.1	6.3	8.6
Төрийн байгууллагын хэрэглээ	2.2	1.7	1.4	0.7	3.6
Хөрөнгийн нийт хуримтлал	-16.2	19.9	4.9	-1.6	9.3
Цэвэр экспорт	8.2	-16.0	-6.4	1.8	-16.4
ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, жилийн дундаж, хувиар)	3.7	7.3	15.2	10.4	6.8
Зэсийн үнэ* (\$/тонн)	6,178	9,315	8,815	8,479	9,145
Алтны үнэ* (\$/трой. унци)	2,267	3,008	3,490	2,647	2,779
Газрын тосны үнэ* (\$/баррел, Brent)	51	59	77	76	76
ДНБ дефлятор (хувиар)	3.7	14.4	17.7	21.8	8.2
(тэрбум төгрөгөөр)					
НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
Нийт орлого ба тусламжийн дүн	10,444	14,306	18,522	24,387	31,375
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	9,464	12,711	17,127	23,295	29,589
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,904	15,630	18,160	22,509	30,365
Нийт тэнцэл	-3,460	-1,324	362	1,878	1,010
Нийт үндсэн тэнцэл	-2,521	-488	1,160	3,028	2,205
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-4,440	-2,919	-1,033	786	-776
МӨНГӨНИЙ СЕКТОР					
M2 мөнгөний өсөлт (хувиар)	16.2	13.8	6.5	26.8	15.2
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	-12.7	6.5	39.9	7.4	51.9
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.5	1.6	1.8	1.9	1.8
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.4	5.8	4.4	5.2	3.9
Зээлийн өсөлт** (хувиар)	-4.0	18.5	7.5	22.7	31.0
(сая ам.доллароор)					
ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ					
Төлбөрийн тэнцэл	787	-222	-727	1,457	622
Урсгал дансны тэнцэл	-675	-2,108	-2,304	121	-2,190
ГВУН	4,534	4,366	3,400	4,921	5,510
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	7.4	5.7	3.4	4.4	4.0
Гадаад валютын ханш					
Валютын ханш USD/MNT (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,390
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,420
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	43.0	41.3	38.8	37.6	39.6
Бодит үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	102.9	102.8	105.7	111.1	120.2

*Bloomberg Terminal

**Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	37,453	43,555	53,852	70,442	79,956
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	26,655	27,092	28,455	30,567	32,054
(өсөлт, хувиар)					
Бодит ДНБ-ий өсөлт	-4.6	1.6	5.0	7.4	4.9
Уул уурхайн	-9.9	0.8	-15.3	23.4	10.8
Уул уурхайн бус	-3.7	1.8	8.2	5.4	4.0
Хөдөө аж ахуй	5.8	-5.5	12.0	-8.9	-28.7
Уул уурхай	-9.9	0.8	-15.3	23.4	10.8
Боловсруулах аж үйлдвэр	3.4	-0.9	6.1	5.1	-1.2
Цахилгаан дулаан	1.8	9.4	3.3	5.0	4.8
Барилга	-3.2	-22.8	8.2	3.1	10.4
Бөөний болон жижиглэн худалдаа	-12.5	5.8	10.1	6.8	6.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-18.2	-7.3	9.2	39.6	23.1
Мэдээлэл, холбоо	5.2	20.7	6.6	17.0	15.5
Бусад үйл ажиллагаа	-2.6	3.8	5.4	5.8	7.8
Цэвэр татвар	-9.4	12.2	11.5	6.6	16.1
Дефлятор	3.7	14.4	17.7	21.8	8.2
(нэгж хувиар)					
ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо					
Хөдөө аж ахуй	0.8	-0.8	1.7	-1.3	-3.6
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.4
Боловсруулах аж үйлдвэр	0.3	-0.1	0.5	0.4	-0.1
Цахилгаан дулаан	0.0	0.2	0.1	0.1	0.1
Барилга	-0.1	-0.9	0.2	0.1	0.3
Бөөний болон жижиглэн худалдаа	-1.4	0.6	1.1	0.8	0.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-1.0	-0.3	0.4	1.8	1.3
Мэдээлэл, холбоо	0.1	0.5	0.2	0.5	0.5
Бусад үйл ажиллагаа	-0.7	1.1	1.6	1.7	2.2
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.8	2.0
(тэрбум төгрөгөөр)					
Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	37,883	44,703	54,878	71,202	80,049
Анхдагч орлого	-3,526	-6,359	-5,072	-7,738	-8,588
Үндэсний нийт орлого	34,357	38,344	49,806	63,463	71,460
Хоёрдогч орлого	769	1,223	1,363	1,378	1,536
Үндэсний нийт цэвэр орлого	35,126	39,566	51,169	64,842	72,997
Нийт дотоод эрэлт	36,953	45,574	58,219	64,404	80,540
Үндэсний хадгаламж	6,556	9,985	15,747	24,317	20,156
Хөрөнгийн нийт хуримтлал	8,383	15,993	22,796	23,880	27,700

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024
	(тэрбум төгрөгөөр)				
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,444	14,306	18,522	24,387	31,375
Ирээдүйн өв сан	914	967	0	416	841
Тогтворжуулалтын сан	66	628	1,395	676	444
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,464	12,711	17,127	23,295	29,589
Татварын орлого	8,512	11,300	15,459	21,484	27,377
Орлогын албан татвар	2,227	3,326	3,827	5,703	8,981
Нийгмийн даатгалын орлого	1,586	2,286	3,038	3,951	4,700
Хөрөнгийн албан татвар	155	201	238	395	460
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,209	2,838	3,946	4,777	5,864
Онцгой албан татвар	777	827	848	790	1,098
Тусгай зориулалтын орлого	17	17	19	22	26
Гаалийн албан татвар	741	939	1,256	1,465	1,792
Бусад татвар,төлбөр, хураамж	800	866	2,288	4,382	4,455
Татварын бус орлого	952	1,412	1,668	1,811	2,212
Нийтлэг татварын бус орлого	785	1,250	1,364	1,452	1,770
Хөрөнгийн орлого	1	2	4	8	7
Тусламжийн орлого	166	160	300	351	435
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,904	15,630	18,160	22,509	30,365
Урсгал зарлага	10,829	12,804	14,229	17,091	22,067
Цалин, хөлс	2,649	2,532	1,666	2,327	5,363
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,202	2,170	2,140	2,758	4,082
Татаас	375	454	537	580	955
Урсгал шилжүүлэг	4,663	6,813	9,088	10,276	10,472
Зээлийн үйлчилгээний төлбөр	939	836	798	1,150	1,195
Гадаад	776	681	694	1,054	1,146
Дотоод	163	155	104	96	49
Хөрөнгийн зардал ба цэвэр зээл	3,075	2,826	3,930	5,418	8,299
Хөрөнгийн зардал	3,034	2,982	3,803	5,188	7,924
Эргэж төлөгдөх цэвэр зээл	41	-156	127	229	374
НИЙТ ТЭНЦЭЛ	-3,460	-1,324	362	1,878	1,010
ҮНДСЭН ТЭНЦЭЛ	-2,521	-488	1,160	3,028	2,205
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-4,440	-2,919	-1,033	786	-776

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024
	(сая ам.доллаар)				
I. УРСГАЛ ДАНС	-675	-2,108	-2,304	121	-2,190
Бараа	1,756	1,370	1,233	4,549	2,947
Экспорт Ф.О.Б (кредит)	6,991	8,136	9,854	13,914	14,750
Импорт Ф.О.Б (дебит)	5,235	6,766	8,622	9,366	11,803
Үйлчилгээ	-1,450	-1,675	-2,355	-2,592	-3,057
Кредит	655	814	1,135	1,587	1,566
Дебит	2,105	2,490	3,490	4,179	4,623
Анхдагч орлого	-1,253	-2,232	-1,615	-2,233	-2,533
Кредит	341	292	344	455	573
Дебит	1,595	2,524	1,959	2,687	3,107
Хоёрдогч орлого	273	429	434	398	453
II. ХӨРӨНГИЙН ДАНС	103	114	154	135	171
Кредит	105	116	166	149	183
Дебит	2	2	12	14	12
III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэг+/зээллэг-)	-1,504	-1,982	-1,644	-1,477	-3,158
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	-1,693	-2,060	-2,428	-2,172	-2,515
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	563	25	445	818	-1,165
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	-6	-8	-11	-2	-13
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-369	60	351	-121	535
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	278	245	298	354	947
Зээл	-803	-501	67	-529	-585
Худалдааны зээл	156	413	-15	54	173
IV. Алдаа болон орхигдуулга	-146	-209	-222	-276	-517
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	787	-222	-727	1,457	622
V. Нөөц хөрөнгө	787	-222	-727	1,457	622
ГВУН	787	-225	-751	1,398	540
ОУВС-гийн зээл	0	-3	-24	-59	-82
Тусгай санхүүжилт	0	0	0	0	0
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллараар)	13,314	15,286	17,150	20,325	23,585
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,534	4,366	3,400	4,921	5,510
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	7.4	5.7	3.4	4.4	4.0
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,813	2,849	3,140	3,466	3,390
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,850	2,849	3,445	3,411	3,420

МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2020	2021	2022	2023	2024
(тэрбум төгрөгөөр)					
Гадаад цэвэр актив	5,816	3,806	2,492	8,959	8,535
Дотоод цэвэр актив	18,664	24,057	27,173	28,665	34,799
Дотоодын цэвэр зээл	19,136	24,298	25,648	29,106	35,343
Бусад цэвэр зүйлс	-472	-241	1,525	-441	-545
M2 мөнгө	24,481	27,863	29,665	37,624	43,334
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	753	847	831	906	978
Харилцах болон хадгаламж	23,728	27,016	28,834	36,719	42,356
(өсөлт, хувиар)					
Жилийн өсөлт					
M2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	15.2
Гадаад цэвэр актив	80.9	-34.6	-34.5	259.6	-4.7
Дотоод цэвэр актив	4.6	28.9	13.0	5.5	21.4
Дотоодын цэвэр зээл	2.3	27.0	5.6	13.5	21.4
ЗГ-аас авах авлага	-29.6	-49.8	107.6	91.3	64.2
Бусад салбараас авах авлага	-2.2	19.2	9.9	19.8	27.0
Улсын байгууллагаас авах авлага	1,492.6	25.0	-5.0	-16.7	13.1
Хувийн сектороос авах авлага	-7.2	18.8	10.8	21.7	27.5
(нэгж хувиар)					
M2 мөнгөний өсөлт дэх оролцоо					
M2 мөнгө	16.2	13.8	6.5	26.8	15.2
Гадаад цэвэр актив	12.4	-8.2	-4.7	21.8	-1.1
Дотоод цэвэр актив	3.9	22.0	11.2	5.0	16.3
Нэмэлт үзүүлэлтүүд:					
Мөнгөний эргэлтийн хурд	1.5	1.6	1.8	1.9	1.8
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	-1.0	16.3	23.6	30.8	13.5
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	3.7	7.3	15.2	10.4	6.8